# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

онг тутмын хэвлэл
12 дугаар сарын 18
№47 /620/

л Улсын хууль
028

гол Улсын Их
лын тогтоол
033

л Улсын Их
ын тогтоол
035



**Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай**

**Төрөөс мөнгөний бодлогын талаар 2010 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай**

**Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай**

баатар хот
09 он

Улсын Их Хурлын Тамгын Газар

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


| | | |
|---|---|---|
| 612. | Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 1028 |
| 613. | Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай | 1029 |
| 614. | Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 1029 |
| 615. | Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн зарим хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 1030 |
| 616. | Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 1031 |
| 617. | Эх, хүүхэлд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай | 1031 |
| 618. | Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 1032 |
| 619. | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай | 1032 |


### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 620. | Төрөөс мөнгөний бодлогын талаар 2010 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай | Дугаар 78 | 1033 |
| 621. | Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай | Дугаар 79 | 1035 |

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

622. Зарлигт өөрчлөлт оруулах тухай Дугаар 154 1088

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

623. Мал, амьтан нэвтрүүлэх боомтын тухай Дугаар 297 1088

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

624. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Дугаар 06 1089

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр — Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн "Монгол Улсыг хөгжүүлэх сангийн төсөв," гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.** Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр — Улаанбаатар хот

## МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2007 оны 02 дугаар сарын 06-ны өдөр баталсан Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2010 оны 01 дүгээр сарын 01–ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — Д.ДЭМБЭРЭЛ**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр — Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нийгмийн халамжийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

**1/ 19 дүгээр зүйлийн 19.1.8, 19.1.9 дэх заалт:**

"19.1.8."Эхийн алдар" нэгдүгээр, эсхүл хоёрдугаар зэргийн одонтой эхэд жилд нэг удаа олгох мөнгөн тусламж;

19.1.9.эхэд жирэмсний 5 сартайгаас эхлэн 12 сарын хугацаанд сар тутам олгох тэтгэмж."

**2/ $19^1$дүгээр зүйлийн $19^1$.4-$19^1$.6 дахь хэсэг:**

"$19^1$.4."Эхийн алдар" нэгдүгээр, эсхүл хоёрдугаар зэргийн одонтой эх жилд нэг удаа мөнгөн тусламж давхардуулахгүйгээр авах эрхтэй.

$19^1$.5.Эх жирэмсний 5 сартайгаас эхлэн 12 сарын хугацаанд сар тутам тэтгэмж авах эрхтэй бөгөөд хэрэв эх хүүхдээ төрүүлсний дараа нас

барсан бол уг хүүхдийн эцэг, эсхүл хууль ёсны асран хамгаалагч, үрчилж авсан эх нь тэтгэмжийг үргэлжлүүлэн авах эрхтэй.

19¹.6.Энэ хуулийн 19¹.4, 19¹.5-д заасан тусламж, тэтгэмжийн хэмжээг Улсын Их Хурал тогтоох бөгөөд уг тусламж, тэтгэмжид шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.".

**2 дугаар зүйл.** Нийгмийн халамжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"24.1.Энэ хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.8-д заасан тусламж, 19.1.9-д заасан тэтгэмжээс бусад тэтгэмжийн болон 17 дугаар зүйлд заасан нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг тухайн жилийн амьжиргааны доод түвшинг харгалзан Засгийн газар тогтооно.".

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр — Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ, ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2009 оны 10 дугаар сарын 30-ны өдөр баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн зарим хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн 1 дүгээр зүйлийн "заалт, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийг тус тус" гэснийг "заалтыг" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** 2009 оны 10 дугаар сарын 30-ны өдөр баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн зарим хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн нэрийн "хэсэг," гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр — Улаанбаатар хот

### ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.4 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын "улсын төсвөөс" гэснийг "Хүний хөгжил сангийн төсвөөс" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хүний хөгжил сангийн 2010 оны төсвийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр — Улаанбаатар хот

### ЭХ, ХҮҮХДЭД ТЭТГЭМЖ ОЛГОХ, ХҮҮХЭД, ЭХ, ГЭР БҮЛД МӨНГӨН ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2006 оны 5 дугаар сарын 05-ны өдөр баталсан Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр | Улаанбаатар хот

### ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн "Монгол Улсыг хөгжүүлэх сан," гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.** Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.9 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.2.5 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2010 оны 01 дүгээр сарын 01–ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр | Улаанбаатар хот

### АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСГИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-19.7 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2010 оны 01 дүгээр сарын 01–ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр | Дугаар 78 | Улаанбаатар хот

**Төрөөс мөнгөний бодлогын талаар 2010 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Төрөөс мөнгөний бодлогын талаар 2010 онд баримтлах үндсэн чиглэл"-ийг хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг улирал тутам Улсын Их Хуралд танилцуулж байхыг Монголбанк /Л.Пүрэвдорж/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

Монгол Улсын Их Хурлын 2009 оны 78 дугаар тогтоолын хавсралт

## ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2010 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Төрийн мөнгөний бодлогын үндсэн зорилт нь ойрын болон дунд хугацаанд инфляцийг нам түвшинд тогтворжуулахад оршино. Энэхүү үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангаж, эдийн засгийн өсөлтийг сэргээж, тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлогыг төсвийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.

### 1. Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд

1.1.2010 онд хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдэх инфляцийг найман хувиас хэтрүүлэхгүй түвшинд байлгаж, цаашид тогтворжуулах, эдийн засгийн мөчлөгийн сөрөг нөлөөг бууруулж, эдийн засгийн өсөлтийг сэргээх бодлого баримтална.

1.2.Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш макро эдийн засгийн суурь нөхцөлөөр тодорхойлогдон уян хатан тогтож байх зарчмыг баримтална. Дэлхийн санхүүгийн зах зээлийн болон гадаад худалдааны нөхцөлийн огцом өөрчлөлтийг төгрөгийн гадаад валюттай харьцах уян хатан ханш, мөнгөний бодлогын арга хэрэгслээр дамжуулан зохицуулж, гадаад валютын албан нөөцийг хамгаална.

1.3.Гадаад валютын дотоод дахь зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлж, төгрөгийн ханш уян хатан тогтох нөхцөлийг сайжруулна.

1.4. Банкны салбарт үүссэн зээлийн тасалдлыг зогсоож, банкны салбараас зээл олгох, зээл авах идэвхийг сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

## 2. Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, цаашид өөрчлөн сайжруулах хүрээнд

2.1.Банкны өөрийн хөрөнгийн хүндрэлийг арилгах, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг бэхжүүлэх, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлогыг Засгийн газартай хамтран олон улсын санхүүгийн байгууллагын дэмжлэгтэйгээр боловсруулж, хэрэгжүүлнэ.

2.2.Иргэд, бизнес эрхлэгчид болон хөрөнгө оруулагчдаас банкны салбарт итгэх итгэлийг нэмэгдүүлэх, банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг тууштай хамгаалах зорилгоор банкны хяналт шалгалтын нэгдсэн тогтолцоог холбогдох байгууллагуудтай хамтран нэвтрүүлнэ.

2.3.Эрсдэлд суурилсан банкны зохистой харьцааны үзүүлэлтийг хангуулан, санхүүгийн сахилга батыг чангатгаж, банкны санхүүгийн тайлан болон өмчлөлийн байдлыг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.

2.4.Банкны системд бүтцийн өөрчлөлт хийж, эрсдэл даах чадвартай, удирдлагын сайн засаглалын зарчимд тулгуурласан, санхүүгийн зуучлалыг үр өгөөжтэй явуулахуйц банкны тогтолцоог бий болгох дунд хугацааны хөтөлбөрийг Засгийн газартай хамтран боловсруулан хэрэгжүүлж эхэлнэ.

2.5.Засгийн газар, Монголбанк хамтарч арилжааны банкны зээлийн хүүг дэс дараатай бууруулах, экспортын орлогыг нэмэгдүүлэхэд ач холбогдол өгч, энэ чиглэлд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж болон хөдөө аж ахуй, хүнсний бүтээгдэхүүний импортыг орлох жижиг, дунд үйлдвэрлэлийг зээлийн бодлогоор дэмжинэ.

## 3. Төв банкны бусад үйл ажиллагааны хүрээнд

3.1.Монголбанкны үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, мөнгөний бодлогын талаархи олон нийтийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор мөнгөний бодлогын зорилт, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний хүлээгдэж байгаа үр дүнгийн талаар тогтмол тайлбарлан таниулж, мөнгөний бодлогын зорилтоо хангаж, олон нийтийн мөнгөний бодлогод итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.

3.2.Монгол Улсын төлбөр тооцооны системийн тасралтгүй, найдвартай байдлыг хангаж, мэдээллийн технологид суурилсан бэлэн бус төлбөрийн хэрэгсэл (мобайл, интернет, карт гэх мэт)-ээр хийх төлбөр тооцооны эрх зүйн орчныг бүрдүүлэх эхлэлийг тавьж, картын гүйлгээг банк хооронд 24 цагаар тасралтгүй дамжуулдаг клирингийн үйлчилгээг нэвтрүүлнэ.

3.3.Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож, банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээлэл авах үйл ажиллагааг эхлүүлж, хуулийн байгууллагатай хамтын ажиллагаагаа сайжруулна.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2009 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр | Дугаар 79 | Улаанбаатар хот |

**Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийг хавсралтаар баталсугай.

2."Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийг Улсын Их Хурлаас баталсан Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2010 оны төсвийн тухай хууль болон бодлогын бусад баримт бичиг, хөтөлбөрүүдтэй нягт уялдуулан хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/, Монголбанк /Л.Пүрэвдорж/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/ болон холбогдох бусад байгууллагад үүрэг болгосугай.

3."Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-д тусгагдсан арга хэмжээ нэг бүрийн хариуцах эзэн, хугацаа, хэмжих нэгж, шалгуур үзүүлэлт, 2010 онд хүрэх түвшинг тодотгон хэрэгжүүлэх дэлгэрэнгүй төлөвлөгөөг боловсруулж танилцуулах, түүнчлэн уг үндсэн чиглэлийн биелэлтийг оны эхнээс жигд хангаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж, хэрэгжилтийн явцыг оны эхний 9 сарын байдлаар болон бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд тус тус танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

Монгол Улсын Их Хурлын 2009 оны
79 дүгээр тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ
2010 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

| Д/д | Зорилт, арга хэмжээ | Хэмжих нэгж, шалгуур үзүүлэлт | 2010 онд хүрэх түвшин |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| | **НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | |
| | **Зорилт 1. Санхүү, эдийн засгийн хүндрэл, бэрхшээлийг даван туулахын тулд эдийн засгийн өсөлтийг дэмжих, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, томоохон хөрөнгө оруулалтын төслүүдийг цогцолбороор нь эхлүүлэх:** | | |
| 1.1 | Эдийн засгийн өсөлтийг дэмжих, дэд бүтэц болон үйлдвэрлэлийн томоохон төслүүдийг эхлүүлэх, нийт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж эдийн засгийн бүтцийг сайжруулах; | дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт /хувиар/ | 7.4 |
| 1.2 | Таван толгойн нүүрсний болон Цагаан суваргын зэсийн ордод түшиглэн уул уурхайн иж бүрэн цогцолбор байгуулах, эрчим хүчээр хангах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, гэрээ, хэлэлцээ хийж, ажлыг эхлүүлэх; | гэрээг байгуулсан байх | - |
| 1.3 | Оюу толгой, Таван толгойн бүтээн байгуулалтыг дэмжих зорилгоор Улаанбаатар-Мандалговь-Таван толгой-Оюу толгойн чиглэлээр хоёр хэлхээтэй 220 кв-ийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд өртөөнүүдийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг эхлүүлэх; | техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг бэлэн болгосон байх | - |
| 1.4 | Таван толгойн нүүрсний ордыг түшиглэн төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар үе шаттайгаар 300 МВт-аас доошгүй хүчин чадалтай дулааны цахилгаан станц байгуулах гэрээг хийх, барилгын ажлыг эхлүүлэх; | техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг бэлэн болгосон байх | |
| 1.5 | Таван толгой-Цагаан суварга-Сайншанд чиглэлийн төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах; | техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг бэлэн болгосон байх | - |
| 1.6 | Дархан, Сэлэнгийн бүс нутагт Төмөртэй, Хустай, Баянгол, Төмөр толгой зэрэг төмрийн хүдрийн орд газруудыг түшиглэн хар | техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, | - |

| | | | |
|---|---|---|---|
| | металлургийн үйлдвэрийн цогцолбор байгуулах гэрээ, хэлэлцээ хийх, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, төмрийн хүдрийг олборлох, баяжуулах үйл ажиллагааг эхлүүлэх; | гэрээ байгуулсан байх | |
| 1.7 | Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, өргөтгөлийн зураг төслийг эцэслэн боловсруулж, өргөтгөл, шинэчлэлийн ажлыг эхлүүлэх; | техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг бэлэн болгосон байх | |
| 1.8 | Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн зэсийн баяжмалыг боловсруулах, зэс хайлуулах үйлдвэрийг барьж байгуулах техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулж, барилгын ажлыг эхлүүлэх, Оюу толгой төслийн хүрээнд зэс хайлуулах үйлдвэр байгуулах судалгааны ажлыг хийж гүйцэтгэх, ядуу хүдрээс катодын зэс гаргах үйлдвэрийг барьж байгуулах, шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлж, катодын зэсний үйлдвэрлэлийг эрс нэмэгдүүлэх; | Эрдэнэтийн зэс хайлуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг бэлэн болгосон байх | - |
| 1.9 | Олон улсын стандартад нийцсэн "Алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэр"-ийг байгуулах судалгаа хийж, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах; | техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан байх | - |
| 1.10 | Жилд 2 сая тонн түүхий тос боловсруулах хүчин чадал бүхий газрын тос боловсруулах үйлдвэрийг бэлэн болсон техник, эдийн засгийн үндэслэлийг баримтлан Дархан-Уул аймагт барих, техникийн зураг төслийг дуусгаж, уг төслийг хэрэгжүүлж эхлэх; | зураг төслийг бэлэн болгосон байх | - |
| 1.11 | Нефть боловсруулах үйлдвэрт түүхий нефть тээвэрлэх байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах; | техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг бэлэн болгосон байх | - |
| 1.12 | Улаанбаатар хотын 220, 110 кв-ийн цахилгаан дамжуулах "Их тойруу" сүлжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах, газрын тосны итгэмжлэгдсэн лаборатори байгуулах; | техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг бэлэн болгосон байх | - |
| 1.13 | Инфляцийн түвшинг хэт өсгөхгүй байх мөнгө, төсөв, санхүүгийн бодлого баримтлах; | инфляцийн түвшин, жилийн эцэст /хувиар/ | 8 |
| 1.14 | Хувийн хэвшилд суурилсан эдийн засгийн хөгжлийн таатай орчныг бүрдүүлэх, боловсруулах үйлдвэр, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих; | дотоодын нийт бүтээгдэхүүнд боловсруулах үйлдвэрийн эзлэх байдал /хувиар/ | 6.5 |

| | | | |
|---|---|---|---|
| 1.15 | Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, зах зээлийн эдийн засгийн тогтолцоог зөв төлөвшүүлэх зорилгоор санхүүгийн, түүхий эдийн болон хөдөлмөрийн зах зээлийг зүй зохистой бүрдүүлж, үйл ажиллагааг нь зүгшрүүлж, аж ахуй, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцох нөхцөл, хэлбэрийг хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулах; | - | - |
| 1.16 | Эдийн засгийн бүтцийг сайжруулж, дотоодын нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэр, үйлчилгээний салбарын эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх бодлого баримтлах; | - | - |
| 1.17 | Үйлдвэрлэл, хэрэглээний зохистой харьцаа бүхий бүтцийг бий болгох, тэргүүний техник, технологийг импортлох, нутагшуулах, боловсруулах үйлдвэрийн өсөлтийг нэмэгдүүлэх бодлого баримтлах; | - | - |
| 1.18 | Өмнөговь аймгийн нисэх онгоцны буудлыг олон улсын буудал болгон өргөтгөх техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг эцэслэн боловсруулах. | - | - |
| **Зорилт 2. Төсвийн орлогын суурийг өргөтгөх, бүртгэл тооцоо, мэдээллийн тогтолцоог сайжруулан төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлж, төсвийн тогтвортой байдлыг хангана:** | | | |
| 2.1 | Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн орлого, зарлагын харьцааг харьцангуй тогтвортой түвшинд байлгах чиглэл баримталж, дотоодын нийт бүтээгдэхүүнд төсвийн алдагдлын эзлэх хувийг бууруулах; | дотоодын нийт бүтээгдэхүүнд нэгдсэн төсвийн орлогын эзлэх хэмжээ /хувиар/ | 33.8 |
| | | дотоодын нийт бүтээгдэхүүнд нэгдсэн төсвийн зарлагын эзлэх хэмжээ /хувиар/ | 38.8 |
| | | дотоодын нийт бүтээгдэхүүнд нэгдсэн төсвийн тэнцлийн эзлэх хэмжээ /хувиар/ | -5 |
| 2.2 | Олон улсын валютын сантай тохиролцсон тогтворжилтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, зээлийн хөрөнгийг оновчтой ашиглах; | Олон улсын валютын сангийн хөтөлбөрийн хүрээнд авах зээл /сая ам.доллар/ | 224.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 2.3 | Төсвийн орлогын боломцоотой бүх эх үүсвэрийг бүрэн дайчилж, оновчтой хуваарилан, үр өгөөжтэй ашиглах; | Төсвийн тухай хуулийн хэрэгжилтээр | - |
| 2.4 | Төсвийн зарлагын хэмжээг орлогын тогтвортой эх үүсвэр болон эдийн засгийн өсөлттэй уялдуулж, үргүй зардлыг хязгаарлан, төсвийн зарлагыг суурь хэмжээнд нь хүртэл бууруулах алхам хийхийн зэрэгцээ тэргүүлэх чиглэлд хөрөнгө оруулалтыг төвлөрүүлэх, үр өгөөжтэй хөгжлийн томоохон төсөл, арга хэмжээнд чиглүүлэх; | хөтөлбөрт суурилсан дунд хугацааны төсвийн төлөвлөлтийг хэрэгжүүлэх, дотоодын нийт бүтээгдэхүүнд төсвийн хөрөнгийн зардлын эзлэх хэмжээ /хувиар/ | 7.2 |
| 2.5 | Төсвийн хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Төсвийн тогтвортой байдлын тухай, Нэгдсэн төсвийн тухай хуулийн төслүүдийг боловсруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 2.6 | Санхүү, эдийн засгийн хүндрэлийг дэс дараатай даван туулах шаардлагатай уялдуулан эдийн засагт өрийн дарамт учруулахгүйгээр гадаад улс, олон улсын байгууллагаас авах зээл, тусламжийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, хяналт зохицуулалтыг дээшлүүлэх; | дотоодын нийт бүтээгдэхүүнд гадаад өрийн үлдэгдлийн эзлэх байдал /хувиар/ | 55-аас хэтрэхгүй байх |
| 2.7 | Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Япон, Энэтхэг Улсын Засгийн газраас төсвийн зээл авах; | зээлийн гэрээг байгуулах, зээл авсан байх | |
| 2.8 | Татварын хууль тогтоомжийг шинээр боловсруулах, боловсронгуй болгох, нийслэл, орон нутгийн татварын тогтолцоотой болох; | иргэд, хуулийн этгээд татварын хуулийг дагаж мөрдөхөд хялбар болсон байх, аймаг, орон нутгийн санхүүгийн эх үүсвэр нэмэгдэж хөрөнгө оруулалтын эх үүсвэртэй болсон байх | - |
| 2.9 | Татвар хураалтын үйл ажиллагааг боловсронгуй болгож, татвар төлөгчдийг татварт хамруулах түвшинг дээшлүүлэх, бэлэн ба бэлэн бус төлбөр тооцоог бүртгэлжүүлэх, далд эдийн засгийн нөлөөллийг багасгах арга хэмжээг хэрэгжүүлэх; | татвар төлөгчдийг татварт хамруулах байдал /хувиар/ | 80-аас дээш |
| 2.10 | Уул уурхай, ашигт малтмал болон байгалийн нөөц ашиглахтай холбогдсон бүх төрлийн албан татвар, төлбөр, хураамжийг бүрэн ногдуулж хураах, түүнд татварын албанаас тавих | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |

| | | | |
|---|---|---|---|
| | хяналтыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх; | | |
| 2.11 | Татвар төлөх нийгмийн сэтгэлгээг хөгжүүлэн, татварын тэгш, шударга байх зарчмыг баримтлан, мэдээллийн тогтолцоог сайжруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 2.12 | "Гаалийн шинэчлэл" төслийн хүрээнд гаалийн үйл ажиллагааг бүрэн автоматжуулах, эрсдэлийн удирдлагад тулгуурласан гаалийн хяналтыг хэрэгжүүлэх, гаалийн байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгох, гаалийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад шуурхай хүргэх тогтолцоог бий болгох; | гаалийн мэдээллийн автоматжуулсан сүлжээ бий болох /хувиар/ | 100 |
| 2.13 | Улсын хилээр нэвтрэх зорчигч, бараа, тээврийн хэрэгслийг хөнгөн шуурхай, чирэгдэлгүй нэвтрүүлэх, шат дамжлагыг цөөлөх, хүнд суртлыг арилгах, хилийн нэгдсэн менежмент болон "Гадаад худалдааны үндэсний цахим нэг цонх"-ыг бий болгох; | "E-standart" системийг цахим байдлаар нэвтрүүлсэн байх | - |
| 2.14 | Монгол Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үүднээс "Транзит Монгол" хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 2.15 | Хилийн боомтуудыг өргөтгөн тохижуулж, хяналтыг зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэх, ложистик терминал барих, хилийн боомтод ажиллах гаалийн улсын байцаагчдын ажиллах нөхцөл, орон сууцны асуудлыг шийдвэрлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 2.16 | Хилийн боомтуудын нэвтрүүлэх чадварыг сайжруулах үүднээс улсын хилээр ачаа тээвэрлэх тээврийн хэрэгсэлд стандарт тогтоож мөрдүүлэх. | бараа, тээврийн хэрэгсэлд тавих гаалийн хяналтын сайжралтын байдал /хувиар/ | 15-20 |
| **Зорилт 3. Банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг дээшлүүлж, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг эрчимжүүлэх, төрийн байгууллагуудын төсөв, санхүүгийн удирдлагын мэдээлэл, дотоод аудит, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно:** | | | |
| 3.1 | Санхүү, эдийн засгийн хүндрэлийн үед хуримтлагдсан чанаргүй зээлийн асуудлыг шийдвэрлэж, банк, санхүүгийн системийн тогтвортой үйл ажиллагааг хангаж, эдийн засгийн өсөлт, бодит салбарын хөгжлийг дэмжсэн бодлогыг хэрэгжүүлэх; | чанаргүй зээлийн хувь буурч, арилжааны банкуудын зээлийн хэмжээ өссөн байх | - |
| 3.2 | Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг олон улсын санхүүгийн зах зээлийн нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсронгуй ... хөрөнгийн зах зээлийн хөгжлийг эрчимжүүлэх, хөрөнгийн | Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон байх | - |

| | | | |
|---|---|---|---|
| | биржийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, олон улсын жишигт хүргэх арга хэмжээ авах; | | |
| 3.3 | Банк, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах зорилгоор банк, санхүүгийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах; | холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт орсон байх | - |
| 3.4 | Монгол Улсын зээлжих зэрэглэлийг шинэчлэн тогтоолгох чиглэлээр олон улсын нэр хүнд бүхий байгууллагуудтай хамтран ажиллах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 3.5 | Банк, санхүүгийн тогтолцоо, үйлчилгээг боловсронгуй болгох хүрээнд хөрөнгө оруулалт, бизнесийн таатай орчныг бүрдүүлж, Хөгжлийн банк байгуулах, зээлийн хүүг бууруулах, хугацааг уртасгах арга хэмжээ авах; | Хөгжлийн банк байгуулсан байх | - |
| 3.6 | Даатгалын зах зээлийн хөгжлийг дэмжиж, түүний нийгэмд үзүүлэх үр нөлөөг өргөжүүлэх хүрээнд "Малын индексжүүлсэн даатгал" төслийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 3.7 | Олон улсын санхүүгийн зах зээлд Монгол Улсын Засгийн газрын бондыг арилжаалах, Монгол Улсын жишиг хүүг тогтоох, өмнө нь арилжаалсан бондын эрсдэлийг удирдан, эргэн төлөлтийг гүйцэтгэх; | санхүүгийн зах зээл дээр Засгийн газрын бондын жишиг хүү тогтсон байх | - |
| 3.8 | Санхүүгийн салбарыг эрсдэлээс хамгаалж хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлж эхлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 3.9 | Нийгмийн даатгалын сангийн бие даасан үйл ажиллагааг дэмжиж, шинэ менежмент нэвтрүүлэх замаар нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг урт хугацааны хөрөнгө оруулалтад ашиглах эрх зүйн орчныг бий болгох; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 3.10 | Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн бүртгэл, дотоод аудит, хяналт-шинжилгээний тогтолцоог бүрдүүлж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 3.11 | Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд бүх сумыг холбох; | холбогдоогүй сумдыг холбож дуусгасан байх<br>шинээр холбох сумын тоо | 31 |
| 3.12 | Ажлын байр бий болгох, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, эдийн засгийн өсөлтийг сэргээхэд чухал ач холбогдол бүхий салбаруудад хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| | шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд Монголбанктай хамтран ажиллах; | | |
| 3.13 | Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд өөрийн хувьцааны 10 хувийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалж, эдийн засгийн хуримтлал бий болгох, иргэдээ хувьцаагаар баталгаажсан хөрөнгөтэй болгох; | - | - |
| 3.14 | Алтыг Монголбанкны Эрдэнэсийн сан болон арилжааны банканд худалдан авах зорилгоор алт олборлох, хадгалах, хамгаалах, тээвэрлэх, тушаах бүх үе шатыг зохицуулсан журмыг Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яамд хамтран боловсруулж мөрдлөг болгон ажиллах; | - | - |
| 3.15 | БНХАУ-ын 300 сая ам.долларын зээлийн ашиглалтыг эрчимжүүлэх. | - | - |
| **ХОЁР. БОДИТ САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | |
| **Зорилт 4. Өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, аж үйлдвэрийн технологи, инновацийг хөгжүүлнэ:** | | | |
| 4.1 | Өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлж эхлэх; | өндөр технологийн талаар төрөөс баримтлах бодлого, "Өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийг батлан хэрэгжүүлж эхэлсэн байх | - |
| 4.2 | Төрийн өмчийн их, дээд сургуулиудын шинжлэх ухаан, технологийн кампус-парк байгуулах ажлыг эхлүүлэн, түүний дэд бүтцийг байгуулах; | шинжлэх ухааны парк байгуулах бэлтгэл ажлыг хангасан байх | - |
| 4.3 | Өндөр технологийг дэмжих хөрөнгийн санг төрийн дэмжлэгтэйгээр байгуулах, технологи, хэрэглээний судалгааг Шинжлэх ухаан, технологийн сангаас түлхүү санхүүжүүлж, энэ чиглэлийн эрдэм шинжилгээний байгууллагуудад хувийн хэвшилтэй хамтран санхүүгийн дэмжлэгийг үзүүлэх тогтолцоонд шилжих; | Өндөр технологийг дэмжих хөрөнгийн сангийн төрийн дэмжлэгийн хэлбэрийг тодорхойлж, эрх зүйн баримт бичгийг боловсруулж, санг байгуулж эхлэх, хувийн хэвшлийн захиалгаар хийгдэж байгаа судалгааны төслүүдийн тоо, хэмжээ нэмэгдэж, | - |

| | | | |
|---|---|---|---|
| | | эрдэм шинжилгээний байгууллагууд, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа өргөжиж технологи, хэрэглээний судалгаанд зарцуулж буй зардал нэмэгдсэн байх | |
| 4.4 | Аж үйлдвэрийн эрэлт, шаардлагад нийцсэн хүний нөөцийг бэлтгэхэд чиглэсэн инженер, технологийн чиглэлийн сургалтыг дэмжиж, аж үйлдвэр, өндөр технологийн чиглэлээр төрийн өмчийн болон хувийн сургуулиудын сургалтыг дэмжих; | өндөр технологийн чиглэлээр бэлтгэгдсэн мэргэжилтний тоо, чанар дээшилсэн байх | - |
| 4.5 | Аж үйлдвэрийн салбаруудын технологи, инновацийн дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, тэргүүн ээлжинд аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэлүүдийг хамруулах; | дэд хөтөлбөрүүдийг боловсруулсан байх | - |
| 4.6 | Аж үйлдвэрийн технологийн судалгаа хийх, технологи дамжуулах чиг үүрэг бүхий нэгжүүдийг байгуулах бэлтгэл ажлыг хангаж, одоогийн нэгжүүдийн бүтэц, чиг үүргийг шинэчлэх; | аж үйлдвэрийн салбаруудын технологийн түвшинг дээшлүүлэх зорилгоор технологийн судалгааны нэгжүүдийг ажиллуулах судалгааг хийж дуусгасан байх | |
| 4.7 | Аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулан төр, их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн хамтарсан судалгааны төсөл хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах; | Төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хийж дуусгасан байх | |
| 4.8 | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрийн үйлчилгээнд шилжүүлэх. | - | - |
| **Зорилт 5. Бодит салбарын хөгжлийг дэмжинэ:** | | | |
| 5.1 | Япон Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн хоёр дахь төсөл"-ийг эхлүүлэх; | холбогдох баримт бичгийг боловсруулсан байх | - |
| 5.2 | Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Улаанбаатар хотын эрчим хүчний системийг сайжруулах, өргөжүүлэх чиглэлээр ажиллах; | холбогдох баримт бичгийг боловсруулан, төслийг хэрэгжүүлсэн байх | |
| 5.3 | Улаанбаатар, Налайх, Эрдэнэт, Дарханд үйлдвэр технологийн парк байгуулах; | байгуулсан байх паркийн тоо | 4 |
| 5.4 | Мянганы сорилын корпорацийн санхүүжилтээр "Хөрөнгийн эрх", "Эрчим хүчийг хэмнэх, агаарын бохирдлыг багасгах" төслийг | холбогдох баримт бичгийг боловсруулан, төслүүдийг | - |

| | | | |
|---|---|---|---|
| | хэрэгжүүлэх; | хэрэгжүүлсэн байх | |
| 5.5 | Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг түшиглэн өндөр хүчин чадлын дулааны цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлж эхлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 5.6 | Улаанбаатар хотод дулаан, цахилгааны 5 дахь эх үүсвэрийг барьж байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, байгаль орчинд нөлөөлөх судалгаа хийх; | техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан байх | - |
| 5.7 | Улаанбаатар хотын цахилгаан болон дулааны эх үүсвэр, шугам сүлжээний хүчин чадлыг сайжруулах, шинэчлэх төсөл боловсруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | |
| 5.8 | Дархан, Эрдэнэтийн дулааны цахилгаан станцуудыг шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | |
| 5.9 | Ховд, Увс аймгийн төвд дулааны шинэ эх үүсвэр барих асуудлыг судалж шийдвэрлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | |
| 5.10 | Дархан, Эрдэнэтийн дулааны цахилгаан станцуудыг шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэх; | Чойрын эдийн засгийн чөлөөт бүсийн тухай хуулийг батлаж, Алтанбулаг, Цагааннуур чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг жигдрүүлэх, Замын-Үүдийн чөлөөт бүсийн хөрөнгө оруулалтын гэрээ хийсэн байх | |
| **Зорилт 6. Эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлж, үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагаанд тавих эрүүл ахуйн шаардлагыг өндөржүүлж, хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл, аюулгүй байдлыг дээшлүүлнэ:** | | | |
| 6.1 | Нутгийн шилмэл омог, арвин ашиг шимт мал, амьтны шалгарсан удмыг сайжруулагчаар ашиглах замаар цөм сүргийн малын тоог нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг дэмжих; | Баталгаажсан цөм сүргийн тоо /сая толгой/ | 15.0 |
| | | шинээр нэмэгдсэн эрчимжсэн аж ахуйн тоо | 500 |
| 6.2 | Гойд ашиг шимт мал болон цөм сүргийн малыг бүртгэлжүүлэх, малын гарвал, ашиг шим, үржил, эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бий болгох, орон нутгийн мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг дэмжих, түүхий эдийн чанарыг урамшуулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 6.3 | Мал, амьтны тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бэлчээрийн | улсын хэмжээнд бэлтгэх | 1000 |

| | | | |
|---|---|---|---|
| | ашиглалт, хамгаалалтыг сайжруулах замаар мал аж ахуйг аливаа эрсдэлээс хамгаалах нөхцөл бүрдүүлэх, отрын бүс нутгийг хамгаалах; | байгалийн хадлангийн хэмжээ /мянган тонн/ | |
| | | улсын хэмжээнд хураан авах таримал тэжээлийн хэмжээ /мянган тонн/ | 20.0 |
| 6.4 | Бэлчээр, тариалангийн талбайн хортон мэрэгч, шавжтай тэмцэх ажлыг зохион байгуулах; | үлийн цагаан оготнотой тэмцэх талбайн хэмжээ /мянган га/ | 720.0 |
| | | царцаатай тэмцэх талбайн хэмжээ /мянган га/ | 626.0 |
| 6.5 | Хүн амын усан хангамжийг сайжруулах зорилгоор сум бүрт 5-аас доошгүй /баг бүрт 1/ худаг гаргаж хөдөөгийн хүн ам, мал аж ахуйг усаар хангах, бэлчээрийг усжуулах, иргэдийн оролцоотойгоор хөв, цөөрөм байгуулах, гар худаг гаргах үйл ажиллагааг дэмжиж, газар доорх усны геофизикийн хайгуул судалгаа хийх; | шинээр гаргах худгийн тоо | 750 |
| 6.6 | Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, Монгол Улсын малыг үхрийн цээж, шүлхий, тархины эд сархиатах өвчнөөс тайван орны нөхцөлийг хангаж Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагад бүртгүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 6.7 | Малын халдварт болон паразиттах өвчний гаралтыг бууруулах, зарим халдварт өвчнөөс эрүүлжүүлэх, ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг сайжруулах, "Бруцеллёзоос эрүүлжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Завхан, Сүхбаатар аймагт хэрэгжүүлэх, хөрөнгийн дотоод эх үүсвэрийг шийдвэрлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 6.8 | Мал эмнэлэг, үржлийн анхан шатны нэгжийн үйл ажиллагааг дэмжих, эмчилгээ, үржлийн ажил, үйлчилгээний чанарыг сайжруулах, оношлогооны чадавхийг дээшлүүлэх; | стандартын шаардлага хангасан мал эмнэлэг, үйлчилгээний нэгж /хувиар/ | 60 |
| 6.9 | "Атрын 3 дахь аян"-ыг эрчимжүүлэх ажлын хүрээнд гол мөрөн бусад эх үүсвэрээр усан сан байгуулж, усалгаатай газар тариалан хөгжүүлэх санаачилгыг дэмжих, газар ашиглалтыг сайжруулан нэгж талбайгаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх, усны хэмнэлттэй технологи нэвтрүүлэх, усалтын системийг | усалгаатай тариалангийн талбайн нэмэгдүүлэх хэмжээ /мянган га/ | 30.0 |

| | | | |
|---|---|---|---|
| | сэргээн засварлах, шинээр ашиглалтад оруулах; | | |
| 6.10 | Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн гурил, төмс, хүнсний ногооны дотоодын үйлдвэрлэл, хангамжийг сайжруулах; | дотоодын ургацаар хэрэгцээт буудайг хангах /хувиар/ | 100 |
| | | дотоодын ургацаар төмсний хэрэгцээг хангах /хувиар/ | 150 |
| | | дотоодын ургацаар хүнсний ногооны хэрэгцээг хангах /хувиар/ | 80 |
| 6.11 | Газар тариалангийн салбарт техникийн шинэчлэл хийж, орчин үеийн техник, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх, дундын техник засварын үйлчилгээний нэгж байгуулах; | өндөр хүчин чадлын техникийн шинэчлэл /хувиар/ | 80 |
| | | техник засварын үйлчилгээ үзүүлэх нэгжийн тоо | 15.0 |
| 6.12 | Тарималын ургамлын үр үржүүлгийн үндэсний төвийг байгуулах; | ганд тэсвэртэй арвин ургац өгдөг үрийг сонгож үржүүлэх, сортын үрийн хүрэлцээ хангамж сайжрах<br>Үр үржүүлгийн төвийн тоо | 1 |
| 6.13 | Үрийн аж ахуй бий болгож, нөөцийн улаан буудай, төмс, хүнсний ногоо хадгалах агуулахын багтаамжийг нэмэгдүүлэх; | агуулахын багтаамж /мянган тонн/ | 45.0-55.0 |
| 6.14 | Хөрсний үржил, шимийг дээшлүүлэх, нэгжээс хураан авах ургацыг нэмэгдүүлэх, бордооны үйлдвэрлэлийг дэмжих; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 6.15 | Хүн амын хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэн жимс, жимсгэний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж "Чацаргана" хөтөлбөрийг хэрэгжүүлэх, нийслэлийн иргэдийг шинэ ургацын хүнсний ногоогоор хангах зорилгоор өвлийн иж бүрэн хүлэмж байгуулахад дэмжлэг үзүүлэх; | жимс, жимсгэнэ тариалах талбайн өсөлтийн хэмжээ, өмнөх оноос /хувиар/ | 25 |
| 6.16 | Сүү бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлж, үйлдвэрийн аргаар боловсруулах сүүний хэмжээг нэмэгдүүлэх, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих; | үйлдвэрийн аргаар боловсруулах сүүний хэмжээ /сая литр/ | 20.0 |
| 6.17 | Мах, махан бүтээгдэхүүний боловсруулалтын технологи болон бүтээгдэхүүний аюулгүй байдлын хяналтыг сайжруулж, экспортын хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлэх, аймгийн төвд махны үйлдвэр байгуулах, борц үйлдвэрлэх тоног төхөөрөмж | үйлдвэрийн аргаар боловсруулах махны хэмжээ /мянган тонн/ | 20.0 |

| | | | |
|---|---|---|---|
| | нийлүүлэх; | | |
| 6.18 | Хөнгөн аж үйлдвэрийн салбарын эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэрүүдийн хоршил бүхий цогцолборын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, Улаанбаатар, Налайх, Эрдэнэт, Дарханд байгуулах ажлыг эхлүүлэх; | цогцолборын тоо | 4 |
| 6.19 | Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжсэн хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, үүний зарим хэсгийг зээлийн баталгааны сан, тоног төхөөрөмжийн лизинг, хүүгийн хөнгөлөлт бий болгоход зарцуулах; | олгосон зээл, хөрөнгө оруулалт, хүүгийн хөнгөлөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/ | 45 |
| 6.20 | Хөдөө аж ахуйн биржийн эрх зүйн орчныг бүрдүүлж, хөдөөгийн иргэдэд бэлтгэсэн түүхий эд, бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд шууд худалдаалах, мэдээллийн технологид суурилсан биржийн сүлжээ байгуулах бэлтгэл ажлыг хангаж, "Органик-Монгол Мах" маркетинг, менежментийн хөтөлбөр хэрэгжүүлэх, малыг эрүүлжүүлэх, экспортлох талаархи төрийн бодлого боловсруулах, ашиг шимт малыг сонгон үржүүлэх, суурин, хагас суурин аж ахуйн хэлбэрээр ферм эрхлэх боломж, нөхцөлийг хангах; | түүхий эд бэлтгэлийн хэмжээ нэмэгдсэн байх | - |
| 6.21 | Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн дотоодын хяналтыг чангатгах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 6.22 | Хүнсний үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP, GHP/ болон аюулыг үнэлэх эгзэгтэй цэгийн хяналт /HACCP/-ын чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 6.23 | Хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг шинжлэх шинэ арга, аргачлалыг лабораторийн шинжилгээнд нэвтрүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 6.24 | Согтууруулах ундааны үйлдвэрлэл, үйлчилгээний цэгүүдийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагуудтай хамтран үзлэг шалгалт тогтмол явуулж, гаргасан санал дүгнэлтийг үндэслэн холбогдох арга хэмжээ авах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 6.25 | Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн чиглэлийн стандартуудыг шинэчилж, хүнсний аюулгүй | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |

| | | | |
|---|---|---|---|
| | байдлын үзүүлэлтүүдийг холбогдох стандартад тусгах; | | |
| 6.26 | Мал аж ахуйн салбарт олон улсын стандартын шаардлагыг хангасан эрүүл ахуй, чанарын хяналтын тогтолцоог нэвтрүүлж мал аж ахуйн гаралтай хүнс, түүхий эд болон бүтээгдэхүүний экспортын хувь хэмжээг 40-өөс доошгүй хувиар нэмэгдүүлж малчдын орлого, амьжиргааны түвшинг тогтвортойгоор дээшлүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд хоёр хэрш, бусад хөгжилтэй орнуудтай хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний хорио цээрийн хэлэлцээрийг байгуулж, холбогдох шаардлага, болзол, нөхцөлийг бүрдүүлэх; | - | - |
| 6.27 | Мал эмнэлэг, үржлийн хяналтыг орон нутагт нэгдсэн удирдлага, зохион байгуулалттай хэрэгжүүлэх санал боловсруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 6.28 | Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан сорилтын лабораториудыг хүнсний болон бусад аюулгүй байдлыг хангахад чиглүүлж, нэг цэгийн үйлчилгээнд шилжүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 6.29 | Төрөөс иргэдэд үзүүлж байгаа баталгаажуулалтын үйлчилгээ, лабораторийн чадавхийг дээшлүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 6.30 | "Төрөөс малчдын талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг улсын төсвийн 2 хувиас багагүй байхаар тооцож төлөвлөх; | - | - |
| 6.31 | Малын эрүүл мэнд, чанарыг сайжруулах болон бэлчээр усжуулалт, тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх, мал эмнэлэг, үржлийн албаны шинэ тогтолцоог бий болгох зэрэг асуудлыг цогцоор нь тусгасан "Монгол мал" үндэсний хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх замаар мал аж ахуйн түүхий эдийг зах зээлд нийлүүлэх нөхцөлийг бий болгох; | - | - |
| 6.32 | Мах, сүү, ноос, ноолуур, арьс шир зэрэг малын гаралтай түүхий эд боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийг төрөөс бодлогоор дэмжих "Аж үйлдвэр II аян" хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх; | - | - |
| 6.33 | Байгаль, цаг уурын эрс тэс уур амьсгалд зохицсон мал аж ахуй, газар тариалангийн эрчимжсэн фермерийн аж ахуйг хөгжүүлэх, малчин, тариаланчдын бүлэг, хоршоо байгуулах ажлыг бүх | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| | талаас дэмжих; | | |
| 6.34 | Жижиг, дунд үйлдвэрийн зээлийн даатгалын хуулийг батлах, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор зээлийн баталгаа, зээлийн даатгал, барьцааны тогтолцоог бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх; | - | - |
| 6.35 | Эргэлтэнд ороогүй газар тариалангийн газрыг эгүүлэн хураах авах; | - | - |
| 6.36 | Өөвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд мал, мах Сэлтгэлийн ажлыг эрчимжүүлж, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх; | - | - |
| 6.37 | Газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийн зохистой байдлыг хангах үүднээс Сэлэнгэ, Төв, Булган, Дархан-Уул аймагт газар тариалангийн бүс нутгийг тогтоож, уг бүс нутагт газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйн хувилбарт үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогоор эрх зүйн орчныг бүрдүүлэх; | - | - |
| 6.38 | Төмс, хүнсний ногооны импортыг хязгаарлах замаар нутгийн экологийн цэвэр бүтээгдэхүүний хэрэглээг бий болгож, тариаланчдыг дэмжих; | - | - |
| 6.39 | Ноос, арьс шир, нэхмэл, сүлжмэл, гар урлал, бэлэг дурсгалын үйлдвэр, хөнгөн блок, асфальт, бетоны зэрэг барилгын материалын импортыг орлох жижиг, дунд үйлдвэр байгуулахыг дэмжих. | - | - |
| **Зорилт 7. Монгол Улсыг үйлдвэржүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ:** | | | |
| 7.1 | Аж үйлдвэржүүлэлтийн хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэх, боловсруулах аж үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх, дэмжих; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 7.2 | Тамсагийн сав газрын Тосон-Уул XIX, Тамсаг-XXI, Буйр-XXII, Дорноговийн сав газрын БХГ-97 талбайн Зүүнбаян, Цагаан-Элсний ордод хайгуулын ажлын хугацаа дуусаж байгаатай холбогдуулан үйлдвэрлэлийн олборлолтод шилжүүлэх ажлыг эхлүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 7.3 | Газрын тосны бүтээгдэхүүний нөөцийг хадгалах орчин үеийн дэвшилтэт техник технологи бүхий төрийн өмчийн агуулахыг шинээр барьж байгуулах. | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |

| | | | |
|---|---|---|---|
| Зорилт 8. **Хүн амын ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэхэд чиглэсэн дэд бүтцийн салбарыг хөгжүүлнэ:** | | | |
| 8.1 | Төв аймгийн Хөшигийн хөндийд олон улсын нисэх буудал барих бэлтгэл ажлыг хангах:<br>-дулаан, усан хангамжийг шийдвэрлэж, Улаанбаатар хотоос 110 кВт-ын цахилгаан дамжуулах шугам татаж, дэд станцыг байгуулах;<br>-Төв аймгийн Зуунмод хотоос шилэн кабель татаж, дамжуулах төхөөрөмжийг байгуулах;<br>-Улаанбаатар-Зуунмод чиглэлийн хатуу хучилттай авто замыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барих | үйл ажиллагааны хэрэгжилтээр<br>үйл ажиллагааны хэрэгжилтээр<br>үйл ажиллагааны хэрэгжилтээр | -<br>-<br>- |
| 8.2 | Увс, Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай аймгийн нисэх буудлын хатуу хучилттай зурвасыг үерийн далангийн хамт барьж дуусган, Увс, Говь-Алтай аймгийн нисэх буудлыг цахилгааны шугамтай холбох; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 8.3 | Дорнод, Хөвсгөл аймгийн нисэх буудлын зорчигч үйлчилгээний цогцолборыг өргөтгөж, багтаамжийг нэмэгдүүлэх. Хөвсгөл, Өмнөговь аймгийн нисэх онгоцны буудлын хатуу хучилттай зурвааст хүчитгэл хийн өргөтгөх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 8.4 | "Чингис хаан" олон улсын нисэх онгоцны буудлын онгоц хөөрч, буух зурвасын хүчитгэлийн ажлыг гэрэлтүүлгийн хамт хийж дуусгах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 8.5 | Ховд аймгийн Булган сумын нисэх онгоцны буудлын хатуу хучилттай зурвас, үерийн даланг барих, гэрэлтүүлгийн систем суурилуулах ажлыг эхлүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 8.6 | Улаанбаатар-Мандалговь-Даланзадгадын чиглэлийн хатуу хучилттай авто замыг төсвийн болон эргэн төлөгдөх нөхцөлөөр барьж эхлэх; | - | - |
| 8.7 | Нислэг хөдөлгөөний бодит ажиглалтын систем, газрын навигацийн тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх ажлыг өргөлжлүүлэн, хангалтыг сайжруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 8.8 | Шинэ төмөр зам тавих, төмөр замыг цахилгаанжуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, ажлыг эхлүүлэх, төмөр замын одоо мөрдөж байгаа олон улсын гэрээ хэлэлцээрийг хуульд нийцүүлэн шинэчлэх, төмөр замын сүлжээг | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |

| | | | |
|---|---|---|---|
| | өргөтгөн хөгжүүлэх үндэсний стратеги бодлогыг боловсруулж батлах, хэрэгжүүлж эхлэх, "Монгол Улсын Төмөр замын хөгжлийн стратегийн нэгдсэн бодлого"-ыг боловсруулж Улсын Их Хурлаар батлуулах; | | |
| 8.9 | Төмөр замын салбарт төрийн болон хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх замаар төмөр замын тээврийн хөдлөх бүрэлдэхүүний паркыг нэмэгдүүлэх; | Төмөр замын тээврийн хөдлөх бүрэлдэхүүний парк нэгжийн өсөлтийн тоо | 250 |
| 8.10 | Улаанбаатар төмөр замын аж ахуйг сайжруулах хүрээнд төмөр замд их засвар хийж, орчин үеийн уулзваргүй төмөр зам ашиглах шинэ технологи нэвтрүүлэх ажлыг судлах; | Их засвар хийх төмөр замын урт /км/ | 108 |
| 8.11 | Улаанбаатар хот орчимд ачааны /чингэлэгийн/ терминал барих техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 8.12 | Замын-Үүд өртөөний нарийн царигийн төмөр замыг галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах хагас автомат хориглолд шилжүүлэх, ачааны терминал барих техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, барилга угсралтын ажлыг эхлүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 8.13 | Улаанбаатар хотод олон улсын төмөр замын вокзал барих техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах; | - | - |
| 8.14 | Зүүнхараад ачааны вагоны хос дугуйг эмхлэн угсрах цехийн эхний хэсгийг ашиглалтад оруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 8.15 | Завхан, Говь-Алтай аймгуудыг цахилгаан эрчим хүчээр тогтвортой хангах арга хэмжээ авах, эдгээр аймгийг эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбох ажлын хүрээнд Могойн голын нүүрсний уурхайг түшиглэн 60 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц, Тэлмэн-Могойн гол, Могойн гол-Мөрөнгийн 110 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барьж байгуулах ажлыг эхлүүлж, 2011 онд ашиглалтад оруулах, баруун бүсийн аймгуудын цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрийн асуудлыг судалж шийдвэрлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 8.16 | Ачаа тээврийн логистик төвийг Улаанбаатар хот орчим, Замын-Үүд, Баян-Өлгий аймгийн Улаанбайшинтад барих бэлтгэл ажлыг хангах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 8.17 | Нийтийн тээврийн үйлчилгээг хийн түлшээр ажилладаг таксигаар хангах арга хэмжээ авч эхлэх; | таксины тоо | 2000-аас доошгүй |

| | | | |
|---|---|---|---|
| 8.18 | Улаанбаатар хот болон томоохон суурин газрын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг хөдөлгөөний аюулгүй байдал, стандартын шаардлага хангасан, багтаамж ихтэй тээврийн хэрэгслээр хангах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 8.19 | Дархан-Уул аймагт автовокзал, авто оношлогооны төвийг барьж, Улаанбаатар хотод орчин үеийн автовокзал барих бэлтгэл ажлыг хангах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 8.20 | Мянганы замыг барих ажилд гадаад, дотоодын санхүүжилтийн эх үүсвэрийг нэн тэргүүнд дайчлан эрчимжүүлэх; | - | - |
| 8.21 | Эргэн төлөгдөх нөхцөлтэй өөрийн хөрөнгөөр барих авто замын ажлуудыг эхлүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 8.22 | "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн хүрээнд баригдаж байгаа Чойр-Сайншанд-Замын-Үүд чиглэлийн Багц-А хэсгийн 176.4 км замыг үргэлжүүлж, Багц-Б хэсгийн 131.3 км, NP-1 багцын 62.2 км, Өргөн сум хүртэлх 18.2 км туслах замуудыг ашиглалтад оруулах, уг төслийн Замын-Үүд чиглэлийн 61.8 км замын хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэж, барилгын ажлыг эхлүүлэх арга хэмжээ авах; | барих замын урт /км/ | 388 |
| 8.23 | Баруун бүс нутагт барих Мянганы замын ажлыг хурдасгах, "Баруун бүсийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн хүрээнд Ховд, Баян-Өлгий аймгуудад Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар барих 216 км, БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр барих 205.3 км, Япон Улсын Ядуурлыг бууруулах сангийн хөрөнгөөр 6 суманд 33 км зам барих ажлыг тус тус эхлүүлэх, Өлгий-Улаанбайшинт чиглэлийн 32.5 км замыг гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр барих асуудлыг шийдвэрлэж, зам барих ажлыг эхлүүлэх; | барих замын урт /км/ | 487 |
| 8.24 | Арвайхээр-Баянхонгорын чиглэлийн авто замыг барьж дуусгах, Хархорин-Цэцэрлэг чиглэлийн 29.3 км, Хархорин-Хужирт чиглэлийн 36.8 км, Халзанбүргэдэй-Солонготын даваа чиглэлийн 180 км хатуу хучилттай авто замуудыг үргэлжлүүлэн барьж, Хархорин-Цэцэрлэгийн 46 км, Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн 109 км, Өгийн нуур-Хөшөө цайдам чиглэлийн 10 км, Цэцэрлэг-Цэцүүх чиглэлийн 37.6 км, Хануйн гүүр- | ашиглалтад оруулах авто замын урт /км/ | 267.6 |

| | | | |
|---|---|---|---|
| | Халзанбүргэдэй чиглэлийн 65 км авто замуудыг ашиглалтад оруулах; | | |
| 8.25 | Улаанбаатар хотын авто замыг шинэчлэх ажлыг эрчимжүүлж, нийт 50 км-ээс багагүй хэмжээний замыг хамруулах,<br>Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хурдны замын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, барилгын ажлыг хийж гүйцэтгэх хөрөнгө оруулагчидтай хийх гэрээ, хэлэлцээрийг эхлүүлэх; | Улаанбаатар хотын авто замын шинэчлэлийн урт /км/<br>авто замыг барих гэрээг байгуулсан байх | 50 км-ээс багагүй<br>- |
| 8.26 | Бүх аймгийн төвийг Улаанбаатар хоттой холбосон хатуу хучилттай авто зам барих ажлыг үргэлжлүүлэх; | - | - |
| 8.27 | Бүх аймгийн төвд хатуу хучилттай шинэ зам барих; | аймаг бүрт барих зам /км/ | 5-10 |
| 8.28 | Улс, орон нутгийн чанартай авто замын урсгал засвар, авто замын арчлалтын ажлыг орон нутгийн иргэдээр гэрээ болон түрээсийн хэлбэрээр хийлгэх замаар ажлын байр шинээр бий болгож, иргэдийг нэмэгдэл орлоготой болгох; | - | - |
| 8.29 | ОХУ болон БНХАУ-ыг холбосон манай улсаар дайран өнгөрөх транзит ачааны хамгийн дөт авто замыг Баян-Өлгий аймгийн Улаанбайшинт-Даянгийн боомтын хооронд гадаадын хөрөнгө оруулалтаар барьж эхлэх; | барих авто зам /км/ | 240 |
| 8.30 | Нарийн сухайт- Шивээ хүрэнгийн төмөр зам, хатуу хучилттай авто замыг барьж байгуулах; | - | - |
| 8.31 | Таван толгой-Оюу толгой-Гашуун сухайтын төмөр замыг барих; | - | - |
| 8.32 | Ховд, Увс аймгийн төвийн дулааны шинэ эх үүсвэр барих техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах; | - | - |
| 8.33 | Төв аймгийн Зуунмод сум-Төмөр замын 4 дүгээр зөрлөгийг хатуу хучилттай авто замаар холбох; | - | - |
| 8.34 | Бүх аймаг, сумын төвүүдэд ахуйн үйлчилгээний төв байгуулж ажиллуулах ажлыг хувийн хэвшилд тулгуурлан эхлүүлж төрөөс дэмжлэг үзүүлж, олон улсын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрт хамруулах; | - | - |
| 8.35 | Булган аймгийн Булган - Хантай чиглэлийн эрчим хүчний шугамыг барьж байгуулах; | - | - |
| 8.36 | Хот тохижилтод зориулан 5.0 тэрбум төгрөг зарцуулах; | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 8.37 | Хотын замын сүлжээний туслах болон явган зорчигчийн замыг сайжруулах ажлын санхүүжилтийг нэмэгдүүлэх; | - | - |
| 8.38 | Хүн амыг орон сууцжуулж, түүнд шаардагдах дэд бүтцэд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх. | - | - |
| **Зорилт 9. Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг өргөжүүлж, өрх бүрт хүргэнэ:** | | | |
| 9.1 | "Өрх бүрт шуудан" хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх; | шуудангийн хайрцгаар хангасан байх айл, өрхийн тоо | 10000 |
| 9.2 | Шуудангийн үндсэн сүлжээний мэдээлэл технологийн тоног төхөөрөмжийг шинэчлэн, нэгдсэн сүлжээ байгуулж, шуудангийн аймагт долоо хоногт хоёр удаа, сум, багт долоо хоногт нэгээс доошгүй удаа хүргэх; | нэгдсэн сүлжээнд холбосон байх хот, аймгийн төв, сум, суурингийн тоо | 22 шуудангийн үндсэн сүлжээ 110 сум |
| 9.3 | ЗИП кодыг улсын хэмжээнд бүрэн нэвтрүүлэх; | ЗИП код хэрэглэгчийн эзлэх хувь | 100 |
| 9.4 | Улаанбаатар хотод тоон телевиз нэвтрүүлэх. | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| **ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | |
| **Зорилт 10. Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах арга хэмжээг эрчимжүүлнэ:** | | | |
| 10.1 | Улаанбаатар хотын агаарын чанарын хяналт шинжилгээний сүлжээг байгуулж, ашиглалтад хүлээн авах, үйл ажиллагааг эхлүүлэх; | агаарын бохирдлыг хэмжих үзүүлэлтийн тоо | 6 |
| 10.2 | Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилгыг дэмжиж, урамшуулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 10.3 | Хот, суурин газарт цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж байгуулах ажлыг өргөжүүлэх; | ногоон байгууламжийн талбайн өсөлт /хувиар/ | 10 |
| 10.4 | Гол, мөрний бохирдлыг багасгах арга хэмжээг хэрэгжүүлж, булаг, шанд, гол, горхины эхийг хамгаалж, тохижуулах. | эхийг нь хамгаалж, тохижуулсан булаг, шандын тоо | 145 |
| 10.5 | Газрын доорх усны хяналт шинжилгээний сүлжээг өргөжүүлэх; | хяналт шинжилгээний цооногийн тоо | 25 |
| 10.6 | "Хог хаягдлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг шинэчлэн боловсруулж, хатуу хог хаягдлыг цуглуулах, ангилах системийг | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |

| | | | |
|---|---|---|---|
| | боловсронгуй болгож, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих; | | |
| 10.7 | Аюултай хог хаягдлыг боловсруулах, устгах, хадгалах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, төвлөрсөн байгууламжийг байгуулах ажлыг эхлүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 10.8 | Уур амьсгалын өөрчлөлтийн хандлагыг үнэлэх, удаан хугацааны прогноз гаргах ажиллагааг шинэ технологид шилжүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 10.9 | Цэвдгийн хяналт шинжилгээний сүлжээг байгуулах; | цэвдгийн хяналт шинжилгээний цэгийн тоо | 18 |
| 10.10 | Экологийн хувьд эмзэг, хамгаалалт шаардагдах гол мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газарт ашигт малтмалын хайгуул, ашиглалт явуулахыг хориглож, уул уурхайн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх арга хэмжээ авах; | хилийн заагийг тогтоож кадастрын зураглал хийсэн байх | - |
| 10.11 | Улаанбаатар хотын ахуйн хог хаягдлыг боловсруулах орчин үеийн технологи бүхий үйлдвэр байгуулах; | - | - |
| 10.12 | Монгол Улсын усны нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор Сэлэнгэ мөрний сав газарт усан сан байгуулах болон Эгийн голд усан цахилгаан станц барих асуудлыг судлах; | - | - |
| 10.13 | Газрын сангийн удирдлагын оновчтой тогтолцоог бий болгож, газрын нэгдмэл сангийн тайлан гаргалтыг боловсронгуй болгох. | - | - |
| **Зорилт 11. Байгалийн нөөцийн тогтвортой менежментийн үндсийг бэхжүүлж, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний чанар, үр дүнг сайжруулна:** | | | |
| 11.1 | Гадаргуугийн урсац, хур тунадасны усыг хуримтлуулах замаар усан сан болон хөв, цөөрөм байгуулах; | байгуулах усан сан, хөв цөөрмийн тоо | 16 |
| 11.2 | Гол, мөрний сав газрын зөвлөлүүдийг байгуулан ажиллуулж, сав газрын усны менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх; | шинээр байгуулах сав газрын зөвлөлийн тоо | 4 |
| 11.3 | Хот, суурин газрын усан хангамжийн эх үүсвэрийн хайгуул, судалгааг хийх; | усан хангамжийн эх үүсвэрийн болон ашиглалтын хайгуул хийх суурингийн тоо | 4 |
| 11.4 | Дэвшилтэт арга, технологи ашиглан ойн санд ой зохион байгуулалт, тооллого хийх замаар улсын хэмжээний ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулан хэрэгжүүлэх | ой зохион байгуулалт хийх талбайн хэмжээ /мянган га/ | 2627.0 |

| | | | |
|---|---|---|---|
| | ажлыг зохион байгуулах; | | |
| 11.5 | Мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, гол мөрөн, булаг, шандын эхийг нөхөн сэргээж, цөлжилт, хөрсний эвдрэл, шар шороон шуурга, элсний нүүлттэй тэмцэх; | ойжуулалтын нийт хэмжээ /мянган га/ | 10.0 |
| 11.6 | Ойн ногоон зүрвас болон ойжуулалтын ажилд шаардагдах үр, тарьц, суулгацын тогтвортой нөөцийг бүрдүүлэх; | бэлтгэх тарьц, суулгацын тоо /сая ширхэг/<br>бэлтгэх үрийн хэмжээ /тонн/<br>үрийн санд нөөцлөх үрийн хэмжээ /кг/ | 35.0<br>2<br>500 |
| 11.7 | Ойн хортон шавжтай тэмцэх ажлын хэмжээг нэмэгдүүлж, түймрээс урьдчилан сэргийлэх чадавхийг сайжруулах; | хортон шавжны судалгаа хийх талбайн хэмжээ /мянган га/<br>ойн хортон шавжтай тэмцэх талбайн хэмжээ /мянган га/ | 2150.0<br>148.5 |
| 11.8 | Цөлжилтөөс сэргийлэх, хөрс хамгаалах эрх зүйн орчныг бий болгон цөлжилттэй тэмцэх сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэх; | цөлжилтийн судалгааны төвийн тоо | 1 |
| 11.9 | Нэн ховор, ховор ан амьтны тооллого явуулж, тархац нөөцийг тогтоох; | тархац, нөөцийг тогтоох зүйлийн тоо | 4 |
| 11.10 | Өндөр уулын болон уулын тайгын бүслүүрийн ашиглалтад өртөмтгий, ашигт ургамлын тархац, нөөцийг тогтоох; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | |
| 11.11 | Улсын тусгай хамгаалалтад авах газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх, судалгааг хийж үндэслэл боловсруулах; | тусгай хамгаалалтад авах газар нутгийн хэмжээ /га/ | 800 |
| 11.12 | Өмнө нь улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хамгаалалтын менежментийн шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах зорилгоор Архангай аймагт ус намгархаг газрын судалгаа, сургалтын иж бүрэн төвийг ашиглалтад оруулан, Улаанбаатар хотын Богдхан ууланд Байгаль орчны эрдэм шинжилгээ, судалгааны цогцолбор төвийг байгуулах ажлыг эхлүүлэх; | эрдэм шинжилгээ сургалт, сурталчилгааны төвийн тоо | 1 |
| 11.13 | "Эрдэс баялгийн талаар төрөөс баримтлах бодлого"-ыг экологийн тэнцвэрт байдлыг хангах эрхэм зорилготой нягт уялдуулан боловсруулах; | - | - |
| 11.14 | Ашигт малтмал, газрын тосны олборлолт эрчимтэй явагдаж байгаа Дорнодын Тамсагбулаг, Сүхбаатарын Төмөртэй, | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| | Өмнөговийн Таван толгой зэрэг орд газар орчмын нутгийн байгаль орчныг хамгаалах, экологийн тэнцэлийг хангах зорилгоор хүнд даацын машин механизмыг тэсвэрлэх чадвар бүхий хатуу хучилттай авто замыг барьж байгуулсны дараа Монгол Улсын хилээр уул уурхайн болон нефть бүтээгдэхүүн гаргадаг болох; | | |
| 11.15 | Байгаль орчны эрсдэл, цөлжилттэй тэмцэх, усжуулалтыг нэмэгдүүлэх хөтөлбөр боловсруулах. | - | - |
| **Зорилт 12. Байгаль орчинд халгүй, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нөхцөлийг сайжруулна:** | | | |
| 12.1 | Аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, Хөвсгөл далайн орчмын аялал жуулчлалын баазуудад нэгдсэн бохир ус цэвэрлэх байгууламжийг байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах; | боловсруулсан байх техник, эдийн засгийн үндэслэлийн тоо | 1 |
| 12.2 | Жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор Хархорины аялал жуулчлалын цогцолборыг байгуулах техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах; | боловсруулсан байх техник, эдийн засгийн үндэслэлийн тоо | 1 |
| 12.3 | Аялал жуулчлалын статистик бүртгэл, мэдээллийн нэгдсэн сүлжээг сайжруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 12.4 | Аялал жуулчлалын томоохон цогцолборуудыг барьж байгуулан аялагч, жуулчдын сонирхлыг татсан аялал жуулчлалын менежментийг хэрэгжүүлэх; | - | - |
| 12.5 | Бүс нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилтын хүрээнд "Хөвсгөл нуур" орчмын нутгийг аялал жуулчлалын бүс нутаг болгон хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх. | - | - |
| **Зорилт 13. Бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжиж, орон нутгийн түүхий эд, боломж, нөөцөд тулгуурласан үйлдвэрлэлийг дэмжинэ:** | | | |
| 13.1 | Эдийн засаг, төсөв, санхүү, татварын бодлогоор төвлөрлийг сааруулж, орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, санхүүгийн төвлөрлийг багасгах, орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, түүний санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох, хөгжүүлэх; | бүс нутгийн хөгжил эрчимжих | |
| 13.2 | Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжих "Говийн өмнөд бүсийн хот байгуулалт, хилийн боомтын хөгжлийн төсөл"-ийн хэлэлцээр байгуулах; | холбогдох баримт бичгийг боловсруулсан байх | - |
| 13.3 | Хилийн цэсийн маргаантай байгаа аймаг, нийслэл, сум, дүүргийн | үйл ажиллагааны | - |

| | | | |
|---|---|---|---|
| | хилийн цэсийг тодотгох, өөрчлөлт оруулах санал боловсруулах; | хэрэгжилтээр | |
| 13.4 | Газрын мэдээллийн үндэсний систем байгуулах ажлыг дуусгаж, бүсийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 13.5 | Оюу толгой, Таван толгой зэрэг стратегийн ач холбогдол бүхий орд газруудыг түшиглэн 10-20 мянган хүн амтай хотуудын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж эхлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 13.6 | Эдийн засгийн хөгжлийн дэд бүс болон нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх хот, суурин газрын хөгжлийн стратегийг боловсруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 13.7 | "Хатгал тосгон", "Ханх тосгон"-ы хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 13.8 | Улаанбаатар хотын хүн амын хэт ачааллыг багасгаж, дагуул хотууд болох Багануур, Налайх, Багахангайг хөгжүүлэх, тэдгээрт зохистой төвлөрлийг бий болгох; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 13.9 | Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх үндсэн чиглэлийг баримтлан орон нутгийн түүхий эд, боломж, нөөцөд тулгуурласан үйлдвэрлэлийг байгуулахад дэмжлэг үзүүлэх; | байгуулах үйлдвэрийн тоо | 21 |
| 13.10 | Шинээр барьж эхлэх орон сууцны хорооллын бэлтгэл ажлыг хангах хүрээнд хот, суурин газрын инженерийн шугам сүлжээг сайжруулах; | шинэчилсэн цэвэр усны шугамын урт /км/ | 50 |
| | | шинэчилсэн бохир ус, дулааны шугам сүлжээний хэмжээ /км/ | 30 |
| 13.11 | Буянт-Ухаагийн орон сууцны хороолол, Яармагийн орон сууцны шинэ хорооллын инженерийн дэд бүтцийг барих ажлыг эхлүүлэх; | цэвэр усны шугамын урт /км/ | 10 |
| | | бохир усны шугамын урт /км/ | 3 |
| 13.12 | "Орон сууцны XIV хороолол", "Орон сууцны VII хороолол", "Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз орчмын хороолол"-ын инженерийн дэд бүтцийг барих ажлыг эхлүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 13.13 | Гэр хорооллыг орон сууцжуулах, газраа байраар солих эрх зүйн орчныг бий болгох; | - | - |
| 13.14 | Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр "Хот байгуулалтын салбар "МОН2301" " төслийг хэрэгжүүлэх; | төсөлд хамрагдах хүний тоо /мянган хүн/ | 20.0 |
| 13.15 | Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар "Дархан | төсөлд хамрагдах хүний тоо | 5.0 |

| | | | |
|---|---|---|---|
| | хотын усан хангамжийг сайжруулах төсөл"-ийг хэрэгжүүлэх; | /мянган хүн/ | |
| 13.16 | "Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарыг хувьчлах, өөрчлөн байгуулах чиглэл"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; | хамрагдах нийтийн аж ахуйн байгууллагын тоо | 5 |
| 13.17 | "100 мянган айлын орон сууц" төслийн хүрээнд бага, дунд орлоготой өрхүүдэд зориулан улсын төсвийн хөрөнгөөр түрээсийн орон сууц барих; | ашиглалтад оруулах орон сууц /айлын тоогоор/ | 324 |
| 13.18 | Улаанбаатар хотын гэр хорооллыг барилгажуулах зорилгоор 1 жилийн хугацаатай түр оршин суух орон сууцны иж бүрэн хороолол 1-ийг Улаанбаатар хотод барих; | ашиглалтад оруулах орон сууц /айлын тоогоор/ | 1000 |
| 13.19 | Улаанбаатар хотын гэр хорооллуудыг дахин төлөвлөлт хийх замаар орон сууцны хороолол болгох ажлыг үргэлжлүүлэх, гэр хорооллын бохирын системийг шинэчлэн сайжруулж, хэсэгчилсэн цэвэрлэх байгууламжид холбох, "Эко бие засах" байгууламжийг нэвтрүүлэх; | гэр хорооллыг бохир ус зайлуулах системд холбох /хувиар/ | 40 |
| 13.20 | Хот болон аймгийн төвүүдийн гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах төслийг боловсруулж, гэр хорооллын доторхи зам, цэвэр усны шугам, гэрэлтүүлэг зэрэг дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх ажлыг үргэлжлүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 13.21 | Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийн технологийг шинэчлэх; | бохир ус цэвэрлэх түвшин, лапийг боловсруулах /хувиар/ | 98.0 |
| 13.22 | Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх замаар орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх; | ашиглалтад оруулах үйлдвэрийн тоо | 10 |
| 13.23 | Барилгын арматур, төмөр хийц, дулаан тусгаарлах материал, шилний үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэх; | ашиглалтад оруулах үйлдвэрийн тоо | 4 |
| 13.24 | Бүсийн тулгуур төв болон хилийн боомтуудад барилгын материалын лабораторийг тоноглох тоног төхөөрөмжийг судалж тогтоох; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 13.25 | Нийтийн зориулалттай орон сууцны барилгын цахилгаан шатыг шинэчилж солих ажлыг эхлүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 13.26 | Хот байгуулалтын тухай хуульд заасан хот байгуулалтын талаарх төрийн бодлого, "Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г богино хугацаанд Улсын Их Хурлаар батлуулах; | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 13.27 | Монгол Улсын хүн амын 45 орчим хувь нь суурьшиж байгаа Улаанбаатар хотын хот байгуулалт болон төлөвлөлтийг хотын хүн амыг эрүүл, аюулгүй амьдрах тааламжтай орон зайн орчныг бүрдүүлэх, хүний аюулгүй байдал, байгаль орчин, экологи, эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэнцвэрт байдлыг хангах үндсэн зарчимд нийцүүлж "Шинэ Улаанбаатар" хөтөлбөр төслийг боловсруулан хот төлөвлөлтийн шинэ бодлогыг хэрэгжүүлж эхлэн, нийслэл хотыг олон улсын жишигт хүргэх. Үүнд:<br>1."Эрүүл аюулгүй орчин-эхлэл" төсөл<br>2. "Орон сууцны шинэ хороолол" төсөл<br>3. "Зам-гүүрэн гарц" төсөл<br>4."Хотын гэрэлтүүлэг, тохижилт-эрчим хүч" зэрэг төслүүд багтах; | - | - |
| 13.28 | "Хөдөөгийн хөгжил" хөтөлбөр боловсруулах; | - | - |
| 13.29 | 2010 оныг "Үйлчилгээний соёл, чанарын жил" болгох, хот, төв суурин газарт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага хүрээлэн байгаа орчноо ногоон байгууламж, гэрэлтүүлэгтэй, цэвэр цэмцгэр болгох. | - | - |
| **Зорилт 14. Байгаль орчин, экологид ээлтэй уул уурхайн салбарыг хөхиүлэн дэмжинэ:** | | | |
| 14.1 | Геологи, эрдэс баялгийн судалгааны болон түүнийг нэгтгэн дүгнэх стандарт, норм, норматив, бусад баримт бичгийг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж батлан мөрдүүлэх; | олон улсын хэмжээний норм, норматив, стандарт хэрэглэх | - |
| 14.2 | Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажлыг эдийн засгийн бүсчлэл, дэд бүтцийг харгалзан тодорхой тектоник, металлогийн бүсүүдийн хэмжээнд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 14.3 | Нутаг дэвсгэрийн геологи, ашигт малтмалын судалгаа хийж, ерөнхий үнэлгээ өгөх, геологийн зураглал, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологи болон бусад сэдэвчилсэн судалгааны ажлыг эрчимжүүлж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 14.4 | Зах зээлийн шаардлагад нийцүүлэн Эрчим хүчний тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 14.5 | Эрчим хүчний хэмнэлтийн талаар хуулийн төсөл боловсруулах; | үйл ажиллагааны | - |

| | | | |
|---|---|---|---|
| | | хэрэгжилтээр | |
| 14.6 | Эрчим хүчний зах зээлийн загварыг гэрээт зах зээлийн загварт шилжүүлэх арга хэмжээ авах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 14.7 | Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдсэн геологийн бүх төрлийн судалгааны ажлын үр дүнгийн тайлан, хавсралт зургуудын 60 хувийг хуулбарлан, цахим сан байгуулах; | цахим сан байгуулах, мэдээллийн хамралт /хувиар/ | 60.0 |
| 14.8 | Байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, шилдэг техник, технологи нэвтрүүлсэн аж ахуйн нэгжийг урамшуулах механизм бүрдүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 14.9 | Стратегийн ач холбогдол бүхий орд тус бүрийн уул-геологи, дэд бүтцийн нөхцөлд тохирсон төслийг боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 14.10 | Байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай тэргүүний техник, технологийн судалгаа хийж жагсаалт гаргах, тэдгээрийг импортлоход дэмжлэг үзүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 14.11 | Алтны нөөцийг өсгөх, орчин үеийн шилдэг техник, технологи нэвтрүүлэх замаар үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч, алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэр байгуулах үйл ажиллагааг дэмжих; | - | - |
| 14.12 | Уул уурхай-металлурги-эрчим хүчний иж бүрэн цогцолборуудыг дагасан хангамж, үйлчилгээ, хүнс, хөдөө аж ахуйн чиглэлийн жижиг, дунд үйлдвэрийн цогц систем байгуулахыг дэмжих; | - | - |
| 14.13 | Гар аргаар ашигт малтмал олборлох эрх зүйн орчныг бүрдүүлэх; | - | - |
| 14.14 | Асгатын мөнгө-холимог металлын ордыг эргэлтэд оруулах талаар 2010 онд лиценз эзэмшигч Орос-Монголын хамтарсан "Монросцветмет нэгдэл"-д шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэж, үйлдвэр барьж байгуулах ажлыг эхлүүлэх; | - | - |
| 14.15 | Нүүрс боловсруулах үйлдвэрийг шинээр байгуулж нүүрсний экспортыг нэмэгдүүлж, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх; | - | - |
| 14.16 | Баталгаажсан нөөцийг нэмэгдүүлэн, олборлолтод хөрөнгө оруулах сонирхол бүхий стратегийн хөрөнгө оруулагчидтай хамтран Мардайн зэрэг ураны ордуудыг ашиглах бэлтгэл хангах. | | |

| | | | |
|---|---|---|---|
| **Зорилт 15. Хөдөө орон нутгийн хүн амын интернет хэрэглээг нэмэгдүүлж, төрөөс иргэдэд хүргэх мэдээллийг цаг алдалгүй, түргэн шуурхай хүрэх боломжийг бүрдүүлнэ:** | | | |
| 15.1 | Орон нутагт нийтийн теле-төвүүдийг байгуулан хүн амын интернетийн хэрэглээг сайжруулах; | орон нутаг дахь интернет хэрэглэгчдийн тоо нэмэгдсэн байх | - |
| 15.2 | Орон нутаг, томоохон хот, суурин газруудын засаг захиргааны байгууллагуудыг төрийн нэгдсэн мэдээллийн сан, сүлжээнд холбож, үйл ажиллагааны бүтээмжийг дээшлүүлэх; | сүлжээнд холбогдсон төрийн захиргааны байгууллагуудын тоо өссөн байх | - |
| 15.3 | Шилэн кабелийн сүлжээнд хамрагдаагүй сумдыг уг сүлжээнд холбох; | шилэн кабелийн сүлжээнд холбогдох сумдын тоо /хувиар/ | 100 |
| 15.4 | Аймгуудын төвд IP/MPLS технологид суурилсан өндөр хурдны түгээх сүлжээг байгуулах; | өндөр хурдны түгээх сүлжээнд хамрагдах аймгийн тоо | 21 |
| 15.5 | Сумдад интернет протоколд суурилсан өгөгдөл дамжууллын түгээх сүлжээ (Access Network)-г байгуулах; | интернет протоколд суурилсан өгөгдөл дамжууллын түгээх сүлжээнд холбогдох сумдын тоо | 110 |
| 15.6 | Улаанбаатар хотын 41 салбар, 21 аймаг, 118 сумын шуудангийн салбарыг нэгдсэн сүлжээнд холбосон мэдээлэл технологийн төв байгуулах; | нэгдсэн сүлжээнд холбогдох шуудангийн салбарын тоо | 41 |
| 15.7 | Сансрын холбооны системийн давтамжийн зурвасыг үр ашигтайгаар ашиглан, газрын станцуудын тоног төхөөрөмжийг шинэчилж, орон нутгийн телевизийн станцийг өргөтгөн телевизийн 10 суваг нэвтрүүлэх; | өргөтгөх сувгийн тоо | 6-8 |
| 15.8 | Бүх сумыг шилэн кабельд холбох замаар үндсэн суурь сүлжээг бүх нийтэд хүртээлтэй болгон, гар утас , интернетийн үйлчилгээг хүргэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 15.9 | Улаанбаатар хотын хэмжээнд төрийн байгууллагуудыг холбох өндөр хурдны суурь сүлжээг байгуулах; | өндөр хурдны сүлжээнд холбогдох төрийн байгууллагуудын тоо нэмэгдсэн байх | - |
| 15.10 | GPS-ийг Улаанбаатар хот, орон нутагт нэвтрүүлэх. | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |

| | | | |
|---|---|---|---|
| **ДӨРӨВ. ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ БОДЛОГО** | | | |
| **Зорилт 16. Нийгмийн халамжийн үйлчилгээнд шинэчлэл хийж, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт оновчтой хүргэх эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна:** | | | |
| 16.1 | Нийтийг хамарсан нийгмийн халамжийн тэтгэмж, дэмжлэг, тусламжийг нийгмийн зорилтот бүлгүүд болон нийгмийн халамж хүртэх шаардлагатай хэсэгт чиглүүлж шинэчлэл хийх; | холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулсан байх | - |
| 16.2 | Нийгмийн халамжийн үйлчилгээг ядуу өрхөд чиглэсэн салбар дундын үйл ажиллагаагаар хүргэх зохион байгуулалтын арга зүйг нэвтрүүлэн эрүүл мэнд, боловсрол, бичил хоол тэжээл, хоол тэжээлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 16.3 | Стратегийн ач холбогдол бүхий болон томоохон орд газраас олсон орлогоос иргэн бүрт 1.5 сая төгрөг хүртээх эрх зүйн орчныг бүрдүүлж, үе шаттай хэрэгжүүлж эхлэх; | - | - |
| 16.4 | Халамжийн үйлчилгээний зохион байгуулалт, менежментийг сайжруулж, түүнд хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудыг татан оролцуулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 16.5 | Хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг шинэчлэн батлуулж, уг аргачлалын дагуу ядуу өрхүүдийн мэдээллийн сан бүрдүүлэх; | мэдээллийн сангийн бүрдүүлэлт эхэлсэн байх | - |
| 16.6 | Гэр бүл, нийгэм, хамт олонд тулгуурласан халамжийн тогтолцоог төлөвшүүлж, халамжийн үйлчилгээг олон улсын жишгээр хөгжүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 16.7 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг стандартын дагуу бий болгох ажлыг эхлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 16.8 | Төвөөс алслагдсан болон говийн бүсийн иргэдэд бүсийн нэмэгдэл олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх; | - | - |
| 16.9 | Өрхийн хэрэгцээ, чадавхи, санаачилгыг дэмжих зорилгоор "Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийг боловсруулах; | - | - |
| 16.10 | Орон нутагт хуурай сүүний үйлдвэрүүд барих; | - | - |
| 16.11 | Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар төрөөс үзүүлж байгаа нийгмийн халамжийн тогтолцоог өөрчилж нийгмийн тодорхой бүлэгт | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| | хандсан нийгмийн халамжийн ялгавартай бодлогыг авч хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бий болгох. | | |
| **Зорилт 17. Нийгмийн даатгалын өнөөгийн тогтолцоог шинэчлэн бэхжүүлнэ:** | | | |
| 17.1 | Тэтгэврийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын урт хугацааны стратегийг тодорхойлж, уг сангийн менежментийн эрх зүйн орчныг бүрдүүлэх; | Хөрөнгө оруулалтын стратеги, холбогдох хууль, эрх зүйн актуудыг гаргасан байна | - |
| 17.2 | Татвар болон нийгмийн даатгалын шимтгэл хураах нэгдсэн тогтолцоог нэвтрүүлэх асуудлыг судалж, тэтгэврийн сангийн тогтвортой байдлыг хангах, сангийн удирдлага, хяналтын тогтолцоог бэхжүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 17.3 | Тэтгэврийн олон давхаргат тогтолцоог бий болгох зорилгоор бүх нийтийн болон нэмэгдэл тэтгэврийн даатгалын эрх зүйн орчныг бүрдүүлэх; | олон давхаргат тэтгэврийн тогтолцооны үзэл баримтлалыг боловсруулсан байх | - |
| 17.4 | Малчин бүрийг нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалд хамруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх. | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| **Зорилт 18. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлж, ядуурлын түвшинг бууруулна:** | | | |
| 18.1 | Залуучууд, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгайлсан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, малчид, оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх; | хөтөлбөр, төслийн хэрэгжилтээр | - |
| 18.2 | Нийтийг хамарсан ажлыг зохион байгуулах арга хэлбэрийг өөрчилж, "Ногоон ажлын байр" санаачилгыг дэмжих; | хамрагдах хүний тоо /мянган хүн/ | 25 |
| 18.3 | Малчдыг сургах, мэргэшүүлэх, улмаар жижиг үйлдвэрлэл эрхлэх, нийтийг хамарсан ажилд татан оролцуулахад туслах замаар орлогыг нэмэгдүүлж, орон нутагтаа тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 18.4 | Хөдөлмөр эрхлэж байгаа хүүхдийн эцэг, эх, гэр бүлийн гишүүдийг орлоготой болгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх; | хөтөлбөрийн хэрэгжилтээр | - |
| 18.5 | Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй үндсэний мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, мэргэшүүлэх, ажлын байран дахь сургалтын хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх; | хөтөлбөрийн хэрэгжилтээр | - |

| | | | |
|---|---|---|---|
| 18.6 | Ядуу өрхүүдийн мэдээллийн санг үндэслэн нэн ядуу өрхийн хөдөлмөрийн чадвартай гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг шинээр бий болгох; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 18.7 | Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн бүртгэл, мэдээлэл, зохион байгуулалтыг сайжруулж, төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоотойгоор тэдний нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх; | албан бус хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн үйлчилгээнд хамруулах чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт хамруулсан байх | - |
| 18.8 | Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн шинэчилсэн өөрчлөлтийн дагуу бүртгэл мэдээллийг сайжруулах; | ажилгүйдлийн түвшин /хувиар/ | 3.1 |
| 18.9 | Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж батлах; | хөдөлмөрийн харилцааны эрх зүйн орчин шинэчлэгдсэн байх | - |
| 18.10 | Ажлын байр нэмэгдүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагыг эдийн засгийн механизмаар дэмжих эрх зүйн орчныг бий болгох талаар санал боловсруулах; | хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулсан байх | - |
| 18.11 | Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцагчдын тоог нэмэгдүүлэх, аж ахуйн нэгж, үйлдвэрийн газрыг түшиглэсэн түргэвчилсэн сургалтаар мэргэжил олгох тогтолцоог урамшуулан дэмжиж, мэргэжлийн зөрүүгээс ажилгүйдэл үүсэх шалтгааныг бууруулах; | - | - |
| 18.12 | Гадаадаас авч байгаа ажилчидтай ижил мэргэжлийн ажилчдыг дотооддоо бэлтгэх, зам, барилга, уул уурхай, үйлдвэр барих зэрэг хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төслүүд дээр монгол ажилчдыг ажиллуулах зорилгоор мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд түргэвчилсэн сургалтаар мэргэжил эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах; | - | - |
| 18.13 | Мэдлэгт суурилсан эдийн засагт хүрэх зорилтыг тодорхой болгох зорилгоор аутсорсингийн үйл ажиллагааг эхлүүлэх, ажиллагсдыг бэлтгэх сургалтыг идэвхжүүлэх. | - | - |
| **Зорилт 19. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлж, ердийн болон халдварт өвчнийг бууруулж, дундаж наслалтыг нэмэгдүүлэх, хүн амын өсөлтийг дэмжихэд чиглүүлнэ:** | | | |
| 19.1 | Эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийн эрсдэлт зан | үйл ажиллагааны | - |

| | | | |
|---|---|---|---|
| | үйлийг өөрчлөх, мэдээлэл, сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг үндэсний түвшинд арга зүйгээр хангах тогтолцоог бүрдүүлэх; | хэрэгжилтээр | |
| 19.2 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, сангийн үр ашгийг нэмэгдүүлэхтэй уялдуулан иргэний эрүүл мэндийн хэрэгцээнд нийцсэн үндэсний эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эмнэл зүйн удирдамж, стандартыг боловсруулах; | - | - |
| 19.3 | Төлбөрийн чадваргүй, хүн амын амьжиргааны түвшингээс доогуур орлоготой болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эмнэлгийн тусламж хөнгөлөлттэй үнээр олгох тогтолцоог судалж, хэрэгжүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 19.4 | Эрүүл мэндийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хүн амд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахад өмчийн хэлбэрийг үл харгалзан эмнэлгийг даатгалын үйлчилгээнд жигд хамруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 19.5 | Яаралтай тусламжийн тогтолцоог түргэн тусламжийн үр дүнтэй үйлчилгээтэй уялдуулан тусламж, үйлчилгээний шатлал бүрт тохирсон загвар боловсруулж, хэрэгжүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 19.6 | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн өвөрмөц хэрэгцээнд нийцэхүйц эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, нөхөн сэргээх тусламж, үйлчилгээний талаар санал боловсруулж, хэрэгжүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 19.7 | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх 4 дүгээр шатны төслийн хэлэлцээр байгуулах; | холбогдох баримт бичгүүдийн төслийг боловсруулж, хэлэлцээр байгуулсан байх | - |
| 19.8 | Эрүүл мэндийн үйлчилгээнд эрхийн бичгийн тогтолцоог нэвтрүүлж, иргэн бүрийг жилд нэг удаа эмнэлгийн иж бүрэн, нарийн мэргэжлийн цогц үзлэг, оношлогоонд хамруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 19.9 | Сум, өрхийн эмчийг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх тогтолцоо болон орон нутагт ажиллах эмч нарын урамшууллыг боловсронгуй болгох замаар анхан шатны эрүүл мэндийн | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |

| | | | |
|---|---|---|---|
| | байгууллагын эмчийн хангалтыг сайжруулах; | | |
| 19.10 | Эрүүл мэндийн үйлчилгээнд орчин үеийн шинжлэх ухаан, технологийн ололтуудыг нэвтрүүлж, улсын хэмжээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зайны оношлогооны цахим эмнэлгийн нэгдсэн сүлжээг бий болгох; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 19.11 | Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээг шинэчилж, Монгол Улсын нутаг дэвсгэрийн алслагдсан аль ч газарт шаардлагатай үед цаг алдалгүй хүрч тусламж үзүүлэх "Үндэсний түргэн тусламжийн сүлжээ" байгуулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 19.12 | Эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бодисын чанарыг баталгаажуулах сорилын лабораторийн үйл ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэх замаар эмийн хангамж, хяналтыг сайжруулж, эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэлд чанарын баталгаажилт, лавлагаа хийх чадавхийг бэхжүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 19.13 | Малчин, ядуу, эмзэг бүлгийн хүн амыг нэхэн үржихүйн эм, хэрэгслээр тогтвортой хангах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 19.14 | Халдварт өвчний халдварыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах арга хэмжээг өргөжүүлж, өвчин эсэргүүцэх тарилга, вакцин, эм хангалтыг нэмэгдүүлэх, малаас хүнд халдварлах өвчний тархалтыг бууруулах; | халдварт өвчнийг бууруулах хувь | 5-аас доошгүй |
| 19.15 | Аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөх, хүүхдийн тасгийн тоног төхөөрөмжийг сайжруулах; | тарилга, вакцины нөөцлөлтийн хувь | 20-иос доошгүй |
| | | халдварт өвчнийг эмчлэх эмийн хангалтын хувь | 90-ээс доошгүй |
| 19.16 | Өсвөр насны охид, жирэмсэн эмэгтэйчүүд, ураг, нярай болон хүүхдийн эрүүл мэндийн тусламжийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор нэг цэгийн цогц үйлчилгээг эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 19.17 | Улаанбаатар хотод телемедицины төв байгуулах,<br>Орхон, Өмнөговь аймагт орчин үеийн эмчилгээ, оношлогооны төв байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг эцэслэн боловсруулж, барьж байгуулах ажлыг эхлүүлэх; | хийж гүйцэтгэх ажил /хувиар/<br>- | 30 |
| 19.18 | Жирэмсэн эмэгтэйчүүд болон ураг, нярайд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, нийслэлд шинээр | 1000 амьд төрөлтөд ногдох нялхасын эндэгдлийг | 17 хүртэл |

| | | | |
|---|---|---|---|
| | | бууруулах тоо | |
| | төрөхийн эмнэлгийг барьж ашиглалтад оруулах, хүүхдийн тусламж, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх, Улаанбаатар хотод 4 дүгээр төрөх эмнэлгийг шинээр барих; | 100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийг бууруулах | 69 хүртэл |
| 19.19 | Эрүүл мэндийн үйлчилгээнд "Урьдчилан сэргийлэх нь эмчлэхээс хялбар" зарчмыг баримталсан шинэ аргачлал нэвтрүүлэх, хүн амыг эрүүлжүүлэх төвийг байгуулахыг дэмжих; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 19.20 | Иргэдийг эрүүл мэндийн орчин үеийн найдвартай, чанартай, хүртээмжтэй үйлчилгээнд хамруулахын тулд төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг байгуулахыг дэмжих; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 19.21 | Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн шинэ барилгын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх, эрүүл мэндийн нэн шаардлагатай өндөр чадлын техник, технологи, багаж, тоног төхөөрөмжөөр хангах; | шинээр хангах багаж, тоног төхөөрөмжийн тоо | 2 |
| 19.22 | Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах зорилгоор бүсийн болон аймаг, нийслэлд шүдний кабинет байгуулах ажлыг дэмжиж, хэрэгжүүлэх; | байгуулах шүдний кабинетийн тоо | 16 |
| 19.23 | 2012 оны олимпийн наадмын бэлтгэлд зориулж нийтийн биеийн тамир, спортын материаллаг баазыг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх, нийтийн биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлогыг батлуулж, хэрэгжүүлж эхлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 19.24 | Улаанбаатар хотын Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт спорт, соёлын ордон барих ажлыг эхлүүлэх; | | |
| 19.25 | Эрүүл мэндийн оношлогооны Үндэсний төв байгуулах; | техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан байх | |
| 19.26 | Уур амьсгалын өөрчлөлт, эрүүл мэндийн стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 19.27 | Хүрээлэн байгаа орчны бохирдол, байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдэн гарах гамшиг, нийтийг хамарсан өвчлөл, хордлого, гэнэтийн аюул ослын үед үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг боловсронгуй болгож, авах арга хэмжээг шуурхай зохион байгуулах нөөц, чадавхийг бэхжүүлэх. | | |

| Зорилт 20. Боловсролын салбарын шинэчлэлийг гүнзгийрүүлж, бүх шатны сургуулийн сургалтын хүртээмж, чанар, тэгш байдалд бодитой ахиц гаргана: | | | |
|---|---|---|---|
| 20.1 | Сургуулийн өмнөх насны хүүхдийн цэцэрлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх, баг бүрийг гэр цэцэрлэгээр хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах; | хамрагдалтын хувь шинээр гэр цэцэрлэгтэй болох багийн тоо | 70 - |
| 20.2 | Бага насны хүүхдийн хөгжлийн стандартыг хэрэгжүүлж эхлэх; | стандарт хангалтын хувь | 93 |
| 20.3 | Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх ажлыг үргэлжлүүлэн 4-7, 9-12 дугаар ангийн сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулан тохирцыг үнэлж, сургалтад мөрдүүлэх; | боловсруулах сургалтын хөтөлбөрийн тоо | 62.0 |
| 20.4 | Ерөнхий боловсролын 12 жилийн сургуульд мөрдөх боловсролын стандартыг шинэчлэн боловсруулах; | боловсруулах стандартын тоо | 20.0 |
| 20.5 | Сургуульд суурилсан мэргэжил дээшлүүлэх тогтолцоо бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлж эхлэх; | стандартын шаардлага хангасан багш хөгжлийн танхимын тоо | 5 хүртэл |
| 20.6 | Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг зохиох, хэвлэх, түгээх ажлыг хичээлийн жилийн өмнө зохион байгуулж, сурах бичгийн хүрэлцээ, хангамжийг сайжруулах; | 12 жилийн сургалттай 1, 3 дугаар ангийн сурах бичгийг хэвлэсэн байх | - |
| 20.7 | Ерөнхий боловсролын сургуулийн компьютерийн тоог нэмэгдүүлж, багш нарыг зөөврийн компьютерээр хангах арга хэмжээг үргэлжлүүлэх; | зөөврийн компьютерийн тоо | 5723.0 |
| | | сургалтын компьютерийн тоо | 4000.0 |
| 20.8 | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг "Үдийн хоол" хөтөлбөрт хамруулах ажлыг эхлэх; | хамрагдах сургууль | 10.0 |
| 20.9 | Сургууль завсардалтыг бууруулж, бүх хүүхдэд бага боловсрол олгох; | бага боловсролын хамран сургалтын цэвэр жин /хувиар/ | 92.7 |
| | | сургууль завсардалтын хувь | 1-ээс доош |
| 20.10 | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр "Эмзэг бүлгийн иргэдэд боловсролын үйлчилгээг хүргэх төсөл"-ийг эхлүүлэх; | дэмжлэг үзүүлэх сургуулийн тоо | 100 орчим |
| 20.11 | Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга, стандартыг зах | шинэчлэн боловсруулах | 100 .0 |

| | | | |
|---|---|---|---|
| | ээлийн эрэлтэд нийцүүлэн шинэчлэх; | стандартын тоо | |
| 20.12 | Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн багшийн хангамж, мэргэжлийн чадавхи, ур чадварыг дээшлүүлэх; | мэргэжил дээшлүүлэх багшийн тоо | 120.0 |
| 20.13 | Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн чадавхийг бэхжүүлэх, чанарын хяналтын тогтолцоог бий болгох; | дотоодын болон гадаадын байгууллагаар магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо | 6.0 |
| 20.14 | Мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх үзэл баримтлалыг боловсруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | |
| 20.15 | Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүд болон их, дээд сургуулиудыг аттестатчилах; | аттестатчилалд хамрагдах мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн тоо | 10 .0 |
| | | аттестатчилалд хамрагдах их, дээд сургуулийн тоо | 5.0 |
| 20.16 | "Дээд боловсролын шинэчлэл 2010-2012" хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлж эхлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 20.17 | Аутсорсингийн мэргэжилтэн бэлтгэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 20.18 | Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг олон улсын стандартад нийцүүлэх; | магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо | 3-аас доошгүй |
| 20.19 | Их, дээд сургуулийн багшийг чадваржуулах хөтөлбөр боловсруулан баталж, чадавхийг нь дээшлүүлэх; | гадаадад мэргэжил дээшлүүлэх багшийн тоо | 100 |
| | | дотоодод мэргэжил дээшлүүлэх багшийн тоо | 150 |
| 20.20 | Эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр гадаадын өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын тоог нэмэгдүүлэх; | тэргүүлэх чиглэлээр гадаад улсад суралцагчдын тоо | 60 |
| 20.21 | Шинжлэх ухаан, өндөр технологи, чанартай боловсролын нэгдэлтэй бүс-их сургуулийн хотхон байгуулахад төрөөс дэмжлэг үзүүлэх; | дэмжлэг үзүүлэх хотхоны тоо | 2 |

| | | | |
|---|---|---|---|
| 20.22 | "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр II"-ийг хэрэгжүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуульд монгол бичгийн сургалтын цогц программ, цахим мэдээллийн Unicode дээр тулгуурласан монгол бичгийг компьютерт ашиглах иж бүрэн программ хангамжийг нэвтрүүлэх; | - | - |
| 20.23 | Оюутны дотуур байрны хүрэлцээг сайжруулах, "Оюутны дотуур байр-20000" хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхлэх; | - | - |
| 20.24 | Математик болон байгалийн ухааны гүнзгийрүүлсэн сургалттай сургуулийг аймаг, дүүрэг бүрт нэгийг алсын зайн сургалтыг ашиглан зохион байгуулж ажиллуулах; | - | - |
| 20.25 | Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг улс орны хөгжлийн зорилтуудтай уялдуулан тодорхойлж, хөрөнгө, хүчийг төвлөрүүлэх; | - | - |
| 20.26 | Хот, хөдөөгийн сургуульд хэрэгжиж байгаа үдийн цай /хоол/ хөтөлбөрийн хүрээнд сурагчдад олгож байгаа бүтээгдэхүүнийг зөвхөн нэмүү өртөг шингэсэн дотоодын бүтээгдэхүүнээр хангах бодлого баримтлах; | - | - |
| 20.27 | Мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт гарч актлагдсан барилга байгууламжид сургалт, үйл ажиллагаа явуулахыг таслан зогсоож, эдгээр барилгыг засах санхүүжилтийг оновчтой шийдвэрлэх. | - | - |
| **Зорилт 21. Үндэсний инновацийн эрх зүйн орчныг бий болгож, шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг хөгжүүлнэ:** | | | |
| 21.1 | Үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлэн хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, инновацийн үйл ажиллагааны санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох; | Инновацийн тухай хуулийг баталсан байх | - |
| 21.2 | Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны санхүүжилтэд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх эдийн засгийн хөшүүрэг бий болгох, аж ахуйн нэгжийн шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд зарцуулсан зардалд татварын хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 21.3 | Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг хөгжүүлэх саналыг хэрэгжүүлж эхлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | |

| | | | |
|---|---|---|---|
| 21.4 | Дэвшилтэт болон уламжлалт технологийг хөгжүүлэх судалгаа, туршилтын баазыг бэхжүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 21.5 | Дэвшилтэт технологи хөгжүүлэх талаар их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгаа, боловсруулалтын ажлыг дэмжих; | дэвшилтэт технологийн судалгаа явуулах лабораторитой болсон байх | - |
| 21.6 | Хүн, мал эмнэлгийн салбарт оношлогоо, эмчилгээний вакцины дотоодын хэрэгцээг хангах үйлдвэрлэл-технологийн үндсийг тавих | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| **Зорилт 22. Соёл, урлагийг хөгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож, соёл, урлагийн үйлчилгээний хүртээмжийг ахиулж, хүний хөгжлийн хэрэгцээнд чиглүүлнэ:** | | | |
| 22.1 | Соёлын өв уламжлалыг хадгалан хөгжүүлэх зорилгоор Соёлын тухай болон Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 22.2 | "Монгол Улсын соёл, урлагийг 2010-2016 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө"-г боловсруулж, батлах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 22.3 | Соёл, урлагийг ивээн тэтгэх хуулийн төслийг боловсруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 22.4 | Үндэсний уламжлалт урлаг, сонгодог болон хүүхдэд зориулсан урлагийг төрөөс дэмжин хөгжүүлэх арга хэмжээ авах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 22.5 | Соёл, урлагийн байгууллагын материаллаг бааз, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хөгжмийн зэмсэг, ном, хэвлэлийн хангалтыг нэмэгдүүлэн, алслагдсан нутаг дэвсгэрийн хүн амд үзүүлэх соёлын явуулын үйлчилгээний чанарыг дээшлүүлэх арга хэмжээ авах. | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| **ТАВ.ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ** | | | |
| **Зорилт 23. Үндэсний аюулгүй байдал, ард түмний язгуур эрх ашгийн үүднээс зохистой тэнцвэрийг хадгалсан гадаад бодлого явуулах орчныг бүрдүүлж, эдийн засгийн үр ашигтай гадаад харилцааг хөгжүүлнэ:** | | | |
| 23.1 | Монгол Улсын гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж эхлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 23.2 | Монгол Улсын худалдааны эрх зүйн орчныг Дэлхийн худалдааны байгууллага болон олон улсын хууль тогтоомжид | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |

| | | | |
|---|---|---|---|
| | нийцүүлэн боловсронгуй болгож, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлэх; | | |
| 23.3 | Эдийн засгийн харилцааг аль болох олон талтай болгох бодлого явуулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 23.4 | Гадаад худалдааг нэмэгдүүлэх зорилгоор Дэлхийн худалдааны байгууллагаас зохих дэмжлэг, туслалцаа авах; | Дэлхийн худалдааны байгууллагын "Худалдааны тусламж" санаачилгыг хэрэгжүүлсэн байх | - |
| 23.5 | Гол түнш орнуудаас үзүүлж байгаа худалдааны хөнгөлөлтийг өргөжүүлж, экспортыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих бодлогыг хэрэгжүүлэх; | Европын Холбооны хөнгөлөлтийн ерөнхий систем (GSP+)-ийг бүрэн ашигласан байх | - |
| 23.6 | Үндэсний болон хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор импортоос хэт хамаарах хамаарлыг бууруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 23.7 | Малын гаралтай түүхий эдийн бүтээгдэхүүний экспортын хэмжээг хоёр дахин нэмэгдүүлэх, улмаар уг бүтээгдэхүүнийг хөгжилтэй орнуудын импортлох түвшинд хүргэх чиглэлээр гадаад орнуудтай хамтран ажиллах. | - | - |
| **Зорилт 24. Олон тулгуурт гадаад бодлогын хүрээнд идэвхтэй үйл ажиллагаа хэрэгжүүлнэ:** | | | |
| 24.1 | Хоёр хөрштэй харилцан ашигтай, тэнцвэртэй харилцах бодлого баримталж, ОХУ-тай стратегийн түншлэлийн харилцааг эдийн засгийн агуулгаар баяжуулж, БНХАУ-тай сайн хөршийн харилцан итгэсэн түншлэлийн харилцааг бэхжүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | |
| 24.2 | АНУ, Япон, Канад, Герман болон Европын Холбооны бусад улстай иж бүрэн түншлэлийн түвшинд харилцах бодлого баримтлах, Энэтхэг, БНСУ, Турк, Австрали, АСЕАН-ны улстай түншлэлийн болон худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 24.3 | Далайд гарцгүй улсын эрх ашгийг идэвхтэй хамгаалсан бодлогыг тууштай явуулж, ОХУ, БНХАУ-ын нутаг дэвсгэр дээгүүр Монголын бараа, бүтээгдэхүүнийг дамжин өнгөрүүлэх таатай орчныг бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |

| | | | |
|---|---|---|---|
| 24.4 | НҮБ, түүний системийн болон олон улсын бусад байгууллагын олон талт үйл ажиллагаанд идэвхтэй оролцон олон улсын хамтын нийгэмлэгт эзлэх байр сууриа бэхжүүлэх, эдийн засгийн хөгжлийг хурдасгахад чиглэсэн тусламж, дэмжлэгийг авах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 24.5 | Бүс нутгийн улс төр, эдийн засгийн харилцаанд идэвхтэй оролцож, өөрийн байр суурийг бэхжүүлэх чиглэлээр ажиллах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 24.6 | Хилийн чанадад байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах, иргэд гадаадад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх, тэдэнд үзүүлэх үйлчилгээг хөнгөн шуурхай, чанартай болгох; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 24.7 | Эх орныхоо түүх, соёл, хөгжлийг гадаадад сурталчлан таниулах, Монголын тухай зөрөг ойлголтыг бэхжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллах. | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| **Зорилт 25. Батлан хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, батлан хамгаалах арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлнэ:** | | | |
| 25.1 | Батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчний тухай, Дайны байдлын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | |
| 25.2 | Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, гадаад бодлогын үзэл баримтлалтай уялдуулан "Төрийн цэргийн бодлогын үндэс" баримт бичигт өөрчлөлт оруулах төсөл боловсруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 25.3 | Батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд гадаадын зарим оронд цэргийн атташе ажиллуулах асуудал боловсруулж, холбогдох шатанд шийдвэрлүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 25.4 | Улсын дайчилгааны нэгдсэн болон яам, аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөөг тодотгох; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 25.5 | Дайчилгааны тухай хуулийн дагуу төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтны цэрэг-стратегийн бэлтгэл сургалтын арга хэлбэрийг боловсронгуй болгож, сургалтын тасралтгүй байдлыг хангах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 25.6 | Дайчилгааны тухай хуулийн дагуу бүх аймаг, нийслэлд дайчилгааны I, II зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтыг зохион байгуулж явуулах; | сургалт зохион байгуулсан байх | - |
| 25.7 | "Зэвсэгт хүчний Ерөнхий зориулалтын цэргийн байлдааны ажиллагааны стратеги-тактик"-ийн болон Зэвсэгт хүчний төрөл | үйл ажиллагааны | - |

| | | | |
|---|---|---|---|
| | мэргэжлийн цэргийг байлдааны бус ажиллагаанд ашиглах үзэл баримтлалыг боловсруулж мөрдөх. | хэрэгжилтээр | |
| **Зорилт 26. Зэвсэгт хүчний байгууллагын эрх зүйн болон материаллаг баазыг хангахад чиглэсэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ:** | | | |
| 26.1 | Энхийг сахиулах ажиллагаанд оролцох зориулалт бүхий хоёр ангийг орон тооны бие бүрэлдэхүүн, зэвсэглэл, техникээр хангаж, НҮБ-ын мандат дор явагдаж байгаа энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд Монгол Улсын зэвсэгт хүчний оролцоог нэмэгдүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | |
| 26.2 | НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны гурав дахь батальоныг байгуулах эхний шатны арга хэмжээг хэрэгжүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 26.3 | Чад Улс дахь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсын зэвсэгт хүчнээс 800 хүнтэй мотобуудлагын батальон оролцуулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 26.4 | Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн зэвсэглэл, техникийг сэргээн сайжруулах технологийн шинэчлэл хийх арга хэмжээг үргэлжлүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 26.5 | Ерөнхий зориулалтын цэргийн байлдааны болон хээрийн албаны дүрэм, төрөл мэргэжлийн цэргийн заавруудыг шинэчлэн мөрдүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 26.6 | Энхийн үйл явц, терроризмын эсрэг аливаа хүчин чармайлтад дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн хоёр талын болон олон талын хамтарсан арга хэмжээ, сургалт, дадлага, цэргийн ажиллагаанд идэвхтэй оролцох; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 26.7 | Зэвсэгт хүчний зэвсэглэл, техникийг шинэчлэх урт хугацааны бодлогын баримт бичиг боловсруулж, мөрдөх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 26.8 | Цэргийн дайчилгааны нөөцийн зарим хэсгийг бүрдүүлэх, сольж шинэчлэх арга хэмжээ авах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 26.9 | "Ерөнхий зориулалтын цэргийн олон талт үүрэг гүйцэтгэх чадавхийг нэмэгдүүлэх" цэргийн дэд төсөл хэрэгжүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 26.10 | "Цэргийн орон сууц хөтөлбөр"-ийг боловсруулж хэрэгжүүлэх, хөтөлбөрийн хүрээнд байгууллагын мэдлийн орон сууц барих; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |

| | | | |
|---|---|---|---|
| 26.11 | Батлан хамгаалахын их сургуулийн удирдлага, зохион байгуулалт, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагааны агуулга, технологийг шинэчлэн, батлан хамгаалах салбар, зэвсэгт хүчний эрэлт хэрэгцээг хангахуйц цэргийн болон иргэний боловсон хүчин бэлтгэх зориулалт бүхий гадаадын өндөр хөгжилтэй орнуудын цэргийн сургуулийн жишиг стандартад нийцүүлж хөгжүүлэх, "Батлан хамгаалахын их сургуулийг 2005-2010 хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"-ийг боловсронгуй болгон, хэрэгжүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 26.12 | "Цэргийн цагдаа" дэд төслийг хэрэгжүүлж, цэргийн цагдаагийн нэг ротыг 2010 оноос энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах бэлтгэлийг хангах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 26.13 | Зэвсэг, хэрэглэлийн засварын үйлдвэр, үйлчилгээний бааз, суурийг бэхжүүлэх; | - | - |
| 26.14 | Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвийг Энхийг сахиулах ажиллагааны олон улсын сургалтын төв болгон өргөжүүлэх; | - | - |
| 26.15 | Цэргийн эмнэлгийг цогцолбор төв болгон хөгжүүлэх арга хэмжээ авах; | - | - |
| 26.16 | Зэвсэгт хүчний байлдааны болон олон талт үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангах чиглэлээр зэвсэгт хүчний ангиудтай байлдааны үүргийн болон тусгай үүргийн команд-штабын сургуулиудыг байгуулах. | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| **Зорилт 27. Зэвсэгт хүчнийг улс орны бүтээн байгуулалтын ажилд оролцуулна:** | | | |
| 27.1 | Сүхбаатар, Баянхонгор, Баян-Өлгий аймагт барилга-инженерийн холимог бүтэцтэй батальоныг шинээр байгуулж, улс орны бүтээн байгуулалтын ажил болон олон улсын энхийг сахиулах үйл ажиллагаанд барилга-инженерийн чиглэлээр оролцуулах; | - | - |
| 27.2 | НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох анги, салбаруудын зэвсэглэл, техникийг шинэчлэх дэд төсөл боловсруулж хэрэгжүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 27.3 | Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн 200 хүний гэрээт болон хугацаат цэргийн албан хаагчдын байр барих; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 27.4 | Батлан хамгаалах салбарт цөлжилттэй тэмцэх зориулалт бүхий | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| | тусгай бүтцийн байгууллага байгуулж ажиллуулах. | | |
| **Зорилт 28. Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг шинэчилж, хяналт шалгалтын арга хэлбэрийг боловсронгуй болгож, мэргэжлийн хяналтын байгууллагын материаллаг баазыг сайжруулж, боловсон хүчний чадавхыг дээшлүүлнэ:** | | | |
| 28.1 | Байгаль орчин, эрүүл мэнд, боловсрол, дэд бүтэц, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний чиглэлийн зарим хууль тогтоомжийг боловсронгуй болгож, хяналт шалгалтын шинэлэг менежментийг нэвтрүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 28.2 | Хууль тогтоомж зөрчих явдлыг хязгаарлаж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн амь нас, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажлын цар хүрээг өргөжүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 28.3 | Хяналт шалгалтын ажилд иргэд, иргэний нийгмийн байгууллага, ялангуяа мэргэжлийн болон төрийн бус байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэх боломжийг судлан, шийдвэрлүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 28.4 | Мэргэжлийн хяналтын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн сүүлийн үеийн ололтыг нэвтрүүлж, удирдлагын мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 28.5 | Төв, орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын хүний нөөцийн чадавхийг сайжруулж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 28.6 | Архангай, Баянхонгор, Дундговь, Хөвсгөл аймгийн мэргэжлийн хяналтын байгууллагын болон нийслэлийн Багануур дүүргэт ажлын байр, хилийн 3 боомтод ажлын байр болон орон сууц барих; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 28.7 | Төслийн шугамаар Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Дорноговь аймгийн Замын-Үүдийн хилийн боомтуудад олон улсын шаардлагад нийцсэн хорио цээрийн байгууламж барих ажлыг эхлүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 28.8 | АНУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Дорнод, Сүхбаатар, Дорноговь зэрэг аймгуудын хилийн боомтод цацрагийн тоног төхөөрөмжийг суурилуулж, ашиглалтад | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |

| | | | |
|---|---|---|---|
| | оруулах; | | |
| 28.9 | БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Нэгдсэн төв лабораторийн барилгын ажлыг эхлүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлэх бэлтгэл ажлыг хангах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 28.10 | Мэргэжлийн хяналтын байгууллагын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх. | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| **Зорилт 29. Гамшгаас хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, олон улсын жишигт хүргэх, гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, гамшгийн аюулыг бууруулах, хор уршгийг арилгах арга хэмжээ авна:** | | | |
| 29.1 | Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 29.2 | Гамшгийн үед хүч, хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх журам боловсруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 29.3 | Улсын хэмжээнд нийтээр дагаж мөрдөх, галын аюулгүй байдлын техникийн стандарт, дүрэм боловсруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 29.4 | Бүх шатны байгууллагуудын гамшгаас хамгаалах арга хэмжээний төлөвлөлтийг боловсронгуй болгох, Гамшгийн эрсдэлийг бууруулах сан байгуулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 29.5 | Гамшгаас хамгаалах улсын болон аймаг, нийслэлийн алба, Онцгой комиссын бэлтгэл, бэлэн байдал, гамшигтай тэмцэх чадавхийг дээшлүүлж, харилцан ажиллагааг сайжруулах. | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| **Зорилт 30. Олон улс, хөрш зэргэлдээ орнуудын гамшгаас хамгаалах үүрэг бүхий байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх, аврах ажлын техник, тоног төхөөрөмжөөр хангах бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлж, гамшгаас хамгаалах чадавхийг нэмэгдүүлнэ:** | | | |
| 30.1 | Олон улсын иргэний хамгаалалтын байгууллагын Гүйцэтгэх зөвлөлд Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газрыг гишүүнээр элсүүлэх; | Гүйцэтгэх зөвлөлд гишүүнээр элссэн байх | - |
| 30.2 | Харилцаа, хамтын ажиллагаатай гадаад улс, олон улсын байгууллагуудтай харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцох, хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх талаар ажиллах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |

| | | | |
|---|---|---|---|
| 30.3 | Онцгой байдлын албаны мэдээллийн техник, программ хангамжийг сайжруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 30.4 | Бие бүрэлдэхүүний аврах, гал унтраах тусгай хувцас, автотехник, багаж хэрэгслийн хангалтыг сайжруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 30.5 | Гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ойртуулах зорилгоор хүн амын нягтрал, гамшгийн эрсдэлийг харгалзан нийслэлийн Баянзүрх дүүрэг, Дорноговь аймгийн Замын-Үүд, Айраг сумдад аврах, гал унтраах анги шинээр байгуулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 30.6 | Гамшгаас хамгаалах чиглэлээр гадаадын байгууллагуудаас аврах зориулалттай автомашин, техник, тоног төхөөрөмжийн тусламж авах, ажиллагсдыг мэргэшүүлэх зэргээр хамтын ажиллагааг өргөжүүлэх. | - | - |
| **Зорилт 31. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлж, орчин үеийн шинжлэх ухаан, техникийн ололтыг нэвтрүүлж, гамшгаас хамгаалах боловсролыг иргэдэд олгож, мэргэжлийн боловсон хүчнийг сурган бэлтгэнэ:** | | | |
| 31.1 | Гамшгаас хамгаалах болон улсын нөөц, түүний зохицуулалтын талаар суурь болон хэрэглээний судалгаа, туршилт, шинжилгээний ажилд орчин үеийн шинжлэх ухаан, техникийн ололтыг нэвтрүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | |
| 31.2 | Гамшгаас хамгаалах нэгдсэн дадлага, сургуулийг 3 аймагт зохион байгуулах; | дадлага сургууль зохион байгуулах аймгийн тоо | 3 |
| 31.3 | Онцгой байдлын албаны бие бүрэлдэхүүний болон гамшгаас хамгаалах улсын албад, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн, ажилтан, оюутан, сурагч, иргэдийн гамшгаас хамгаалах сургалтын чанарыг сайжруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 31.4 | Онцгой байдлын албаны офицер, ахлагч нарыг гадаад улс, олон улсын байгууллагаас зохион байгуулах сургалтад хамруулах, суралцагсдын тоог нэмэгдүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 31.5 | Олон улсын ба дотоодын аврагчдын болон галын техник, спортын тэмцээнийг зохион байгуулах, оролцох. | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| **Зорилт 32. Улсын болон орон нутгийн нөөцийн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулна:** | | | |
| 32.1 | ОХУ-ын Улсын нөөцийн агентлагтай улсын нөөцийн бараа | үйл ажиллагааны | |

| | | | |
|---|---|---|---|
| | материалын бүрдүүлэлт, хадгалалт, үйлчилгээ хийх чиглэлээр хамтран ажиллаж, харилцан туршлага солилцох; | хэрэгжилтээр | |
| 32.2 | Эдийн засгийн бүс, аймаг, сумдын хэмжээнд орон нутгийн гамшгийн нөөцтэй байх чиглэлээр өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 32.3 | Газрын тосны бүтээгдэхүүний нөөцийн сав, агуулахын засвар үйлчилгээ хийх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 32.4 | Цахилгааны, дулааны эрчим хүчний зориулалт бүхий тоног төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 32.5 | Улаанбаатар хотод 1000 тонныn багтаамжтай хөргүүрийн аж ахуй /махны зоорь/-г байгуулах. | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| **ЗУРГАА.ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ** | | | |
| **Зорилт 33. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнг сайжруулна:** | | | |
| 33.1 | Төрийн байгууллагын үйлчилгээний стандартыг боловсруулан батлуулж, төрийн байгууллагуудад үе шаттай нэвтрүүлэх; | төрийн байгууллагын үйлчилгээний стандартыг баталсан байх | - |
| 33.2 | Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг хянах цахим, нээлттэй системийг бий болгох; | цахим систем бий болгосон байх | - |
| 33.3 | Төр, иргэний нийгмийн түншлэл, харилцан итгэлцлийг бэхжүүлж, хөгжүүлэх; | иргэний нийгмийн байгууллагаас төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих эрх зүйн орчныг бүрдүүлсэн байх | - |
| 33.4 | Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх, энэ чиглэлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох; | Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм батлагдсан байна | - |
| 33.5 | Төрийн бодлого, үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үр нөлөөг дээшлүүлэх; | хяналт-шинжилгээ, үнэлгээний эрх зүйн орчныг боловсронгуй болгосон байх | - |
| 33.6 | Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг эдийн засгийн чадавхи, зах зээлийн байдал, хүн амын тоо зэрэгтэй нь уялдуулан | орон нутгийн бие даасан байдлыг хангах чиглэлээр | - |

| | | | |
|---|---|---|---|
| | шинэчлэх, орон нутгийн бие даан хөгжих боломжийг нэмэгдүүлэх; | холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан байх | |
| 33.7 | Төрийн байгууллагын бүтцийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй нь уялдуулан боловсронгуй болгох; | төрийн албаны бүтэц цомхон болж, давхардал арилж, иргэдэд үйлчлэх байдал шуурхай болсон байх | - |
| 33.8 | Орон нутгийн хөгжлийг хангах, нутгийн өөрөө удирдах байгууллагын төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлэх; | - | - |
| 33.9 | Улаанбаатар хотын гэр хорооллын иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах зорилгоор хороо, цагдаа, өрхийн эмнэлгийн цогцолборыг 20 хороонд барих; | - | - |
| 33.10 | Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх мэдлийг нэмэгдүүлэх, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, төрийн хүнд суртлыг арилгах, төрийн үйл ажиллагаанд тавих төрийн бус байгууллага, иргэний нийгмийн хяналтыг бий болгож, төрийн байгууллагын үйл ажиллагаа, улсын төсвийн зарлагын гүйцэтгэл, орлогын төлөвлөлтөд хяналт хийж хэлэлцүүлдэг болох; | - | - |
| 33.11 | Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан төсвийн ерөнхийлөн захирагч болон төрийн албан хаагчтай хариуцлага тооцох, ил тод, шуурхай механизм бий болгож хэрэгжүүлэх; | - | - |
| 33.12 | Нийслэл, дүүргийн чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх эдийн засгийн үндэс, удирдлагын бие даасан эрх хэмжээ, байгууллага, аж ахуйн нэгж, иргэд болон засаг захиргаа, нутаг, дэвсгэрийн бусад нэгжтэй харилцах, нийслэл, дүүргийн статуст шинэтгэл хийх, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж батлуулах; | - | - |
| 33.13 | Улсын Их Хурлын гишүүдийн зөвлөхийн орон тоог бий болгох; | - | - |
| 33.14 | Хот, тосгоны хөгжлийг эрчимжүүлэх зорилгоор засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн байдал, эдийн засгийн хөгжлийн бие даасан байдлыг хангах чиглэлээр Улсын Их Хурлын бүтцэд Түр хороо байгуулж ажиллуулах. | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| **Зорилт 34. Хууль тогтоомжийн төсөл боловсруулахад шинжлэх ухааны үндэслэлтэй, боловсруулалтын шаардлагыг сайтар хангасан байх зарчмыг баримтлан эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлнэ:** | | | |
| 34.1 | Хууль тогтоомж хоорондын зөрчлийг арилгах, уялдаа холбоог сайжруулах ажлын хүрээнд иргэн, аж ахуйн чиглэлийн хууль тогтоомжийн давхардал, хийдлийг арилгах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 34.2 | Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх дунд хугацааны хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх; | хөтөлбөрийн төслийг боловсруулсан байх | - |
| 34.3 | Иргэний нисэхийн тухай хуулийг шинэчлэн батлуулж, иргэний нисэхийн багц дүрмийг боловсронгуй болгох; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 34.4 | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж мөрдүүлэх, хувийн хэвшил, салбар бүрийн жишиг гэрээний төслүүдийг боловсруулах; | Эдийн засгийн салбар, хувийн хэвшлийн жишиг гэрээний төслийг боловсруулсан байх | - |
| 34.5 | Нислэг, техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах тухай хуулийг батлуулж, холбогдох дүрэм журмыг боловсронгуй болгох; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 34.6 | Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, холбогдох дүрэм, журмыг боловсронгуй болгох; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 34.7 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг шинэчлэн батлуулж, холбогдох дүрэм, журмыг боловсронгуй болгох; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 34.8 | Барилгын салбарын норм, дүрэм, нормативын баримт бичгийг хянаж боловсронгуй болгох, шинэчлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 34.9 | Үндэсний хууль тогтоомж, олон улсын гэрээний уялдааны талаар судалгаа хийж, шүүх эрх мэдлийн хүрээнд олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх арга замыг тодорхойлох; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 34.10 | Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сүлжээний интернетийн хурдыг хэрэглэгчдийн ачааллыг даахуйц хэмжээнд хүртэл нэмэгдүүлж, тасралтгүй, найдвартай үйлчилгээ үзүүлэх байдлыг хангах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 34.11 | Цахим засаглал хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх, цахим засаглалын EGOV.MN хөтөлбөр боловсруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 34.12 | Улаанбаатар хотод "Холбоо, хяналт, мэдээллийн нэгдсэн сүлжээ" төсөл хэрэгжүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |

| | | | |
|---|---|---|---|
| 34.13 | Улаанбатар хотын гудамж, талбай, олон нийтийн газарт телекамер суурилуулах ажлыг иргэд, олон нийтийн туслалцаа, дэмжлэгээр хийж гүйцэтгэх; | хяналтад авсан байх объектын тоо | 10-аас доошгүй |
| 34.14 | Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх улс, аймаг, сумдын санд жил бүр санхүүгийн дэмжлэг узүүлж, мал хамгаалах малчдын бүлгийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, өмч хөрөнгөө хамгаалдаг болоход малчдын үүргийг нэмэгдүүлэх, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг бүхий сумдын хэсгийн төлөөлөгчийн ажиллах нөхцөл боломжоор хангах, шаардлагатай техник, хэрэгсэл, унаагаар хангах арга хэмжээ авах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 34.15 | Хүний эрхийн талаарх сургалт, сурталчилгааны ажлыг эрх зүйн албан бус сургалттай уялдуулан нийтэд хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 34.16 | Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан эрх зүйн хэм хэмжээ тогтоосон захиргааны актыг бүхэлд нь судалж, хуульд нийцээгүй актыг хүчингүй болгох арга хэмжээ авах, агентлагийн даргын нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг бүхэлд нь судалж, хуульд нийцээгүй шийдвэрийг хүчингүй болгох арга хэмжээ авах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 34.17 | Террорист үйлдлийн эсрэг сөрөг тусгай ажиллагаанд оролцох үүрэг бүхий цагдаа, дотоодын цэргийн тусгай нэгж, салбарыг өргөтгөн зохион байгуулах, террорист үйлдлийн эсрэг сөрөг тусгай ажиллагаа явуулах чиглэлээр цагдаа, дотоодын цэргийн албан хаагчдыг сургалтад хамруулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 34.18 | Садар самуунтай тэмцэх, нэн ялангуяа хүн худалдаалах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх тусгай чиг үүрэг бүхий цагдаагийн нэгжийг байгуулах; | байгуулах нэгжийн тоо | 1.0 |
| 34.19 | Цагдаагийн албан хаагчийн ажлын дундаж ачааллыг тогтоох судалгаа хийж, цагдаагийн албан хаагчийн /олон улсын жишгээр 500 хүнд 1 цагдаагийн албан хаагч ногдохоор тооцож/ орон тоог нь бодит ажлын ачаалалд нийцүүлэх арга хэмжээ авах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 34.20 | Монгол-Хятадын хилийн дэглэмийн гэрээ, Хилийн боомт болон Монгол-Оросын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай | нэмэлт, өөрчлөлт оруулах эрх зүйн актын тоо | 2.0 |

| | | | |
|---|---|---|---|
| | хэлэлцээрүүдийг шинэчлэх; | | |
| 34.21 | "Цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэм", "Цагдаагийн хүрээний ба эргүүл, харуулын албаны дүрэм", "Цагдаагийн сахилгын дүрэм", "Дотоодын цэргийн алба ажиллагааны дүрэм"-д нэмэлт, өөрчлөлт оруулах; | нэмэлт, өөрчлөлт оруулах эрх зүйн актын тоо | 4.0 |
| 34.22 | Цагдаагийн академи, цагдаагийн мэргэжлийн сургалт, судалгааны төвийг шаардлагатай техник, хэрэгслээр хангах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 34.23 | Хилийн цэргийн дээд сургуульд үндсэн болон давтан сургах дамжааны сонсогчдын дотуур байр барих ажлыг эхлүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 34.24 | Захиргааны ерөнхий хууль, Захиргааны процессын хуулийн төсөл боловсруулж батлуулах; | - | - |
| 34.25 | Төр-иргэний итгэлийг бэхжүүлэх, төрийн үйлчилгээг сайжруулах, ил тод, шударга, хүнд сурталгүй болгож, бүх шатны төрийн албан хаагчийн ажил үүргийн биелэлтийг дүгнэж цалин урамшууллалтай нь холбож, хариуцлагыг дээшлүүлэх; | - | - |
| 34.26 | Иргэний эрх зүйн шинэчлэлийг хийх; | - | - |
| 34.27 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг өөрчлөх; | - | - |
| 34.28 | Алт тушаалт, алтны нөөц ашиглалтын лиценз, байгаль орчны нөхөн сэргээлтийг шалгах, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох; | - | - |
| 34.29 | Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Улсын төсвийн төсөл боловсруулах үе шат, үйл явцыг шинэчлэн, нээлттэй, үр ашигтай болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх. | - | - |
| **Зорилт 35. Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангана:** | | | |
| 35.1 | Олон улсын жишиг стандартад нийцсэн архивын нэгдсэн цогцолбор барих ажлыг эхлүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | |
| 35.2 | Төрийн архивын мэдээлэл, эрэлт хайлтын автоматжуулсан | цахим хэлбэрт шилжүүлэх | 10 |

| | | | |
|---|---|---|---|
| | нэгдсэн сан байгуулах, байгууллагын үйл ажиллагаанд цахим бичиг хэргийн тогтолцоог нэвтрүүлэх; | архивын баримтын хувь | |
| 35.3 | Цагдаагийн байгууллагын авто парк, зэвсэг, тусгай хэрэгслийн хангалтыг төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар шийдвэрлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 35.4 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах ажилд иргэд, иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах, тэдгээрийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд онцгой анхаарах, нийгмийн хэв журам хамгаалах чиглэлээр ажилладаг цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдыг хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах арга хэмжээ авах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 35.5 | Алслагдсан сум, дүүрэг, хороодод кобан, бичил хэсэг барьж байгуулах; | барьж байгуулах кобаны тоо | 35.0 |
| 35.6 | Ашиглалтын хугацаа нь дууссан хорих анги, цагдан хорих байруудыг шинэчлэн, олон улсын жишигт нийцүүлэн барьж байгуулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 35.7 | Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй болон хаалттай тогтолцоонд шилжүүлэх асуудлыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулж, ялтныг хуульд заасан шаардлага, олон улсын стандарт, жишигт нийцсэн нөхцөлд ял эдлүүлэх, ялтныг нийгэмшүүлэх ажилд төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх, хорих анги, цагдан хорих байруудыг орчин үеийн телекамер, дохиоллын систем, тоног төхөөрөмжөөр хангах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 35.8 | Улсын хил хамгаалалтад шинэ загварын харах цамхаг, нисгэгчгүй агаарын харах хэрэгслийг туршилтын журмаар ашиглах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 35.9 | Хилийн аюулгүй байдлын мэдээллийн тусгай сан, сүлжээ байгуулах техник, зохион байгуулалтын арга хэмжээ авч, Хил хамгаалах ерөнхий газарт сансрын холбооны суурин станц байгуулах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |

| | | | |
|---|---|---|---|
| 35.10 | Хилийн ангиудыг дохионы бууны сум, туулах чадвар сайтай, техник, эдийн засгийн өндөр үзүүлэлттэй автомашин, бусад техникээр хангах; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 35.11 | Дуу авиа, дүрс бичлэгт шинжилгээ хийх төрөлжсөн лаборатори байгуулах; | байгуулсан байх төрөлжсөн лабораторийн тоо | 2 |
| 35.12 | Гэмт хэрэгтэй тэмцэх, арга үйлдлийг нотлох ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор гисто-химийн, гарын мөрний, биологийн гаралтай объектууд, ДНХ /дархлалын нийлмэл хам шинж/-ийн шинжилгээний лабораториудыг техник, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 35.13 | Улсын хилийг хамгаалах үүргийг "Мэргэшсэн гэрээт хилчин"-ээр гүйцэтгүүлэх тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлэх; | гэрээт хилчний албанд шилжүүлэх хилийн заставын тоо | 12 .0 |
| 35.14 | "Бүсчилсэн хамгаалалт" төслийг говь, цөлийн бүсэд туршиж, цаашид бусад бүсүүдэд үе шаттайгаар хэрэгжүүлэх; | төсөлд хамрагдах улсын хилийн урт /км/ | 2011.7 |
| 35.15 | Хилийн шалган нэвтрүүлэх үйл ажиллагааг хөрш орнуудын жишигт хүргэж, хилийн боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх;<br>-Боршоо-Хандгайт, Ханх-Мондын хилийн боомтыг олон улсын зэрэглэлд шилжүүлэх; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 35.16 | Монгол Улс, БНХАУ-ын хилийн "Буйр нуур"-ын хэсэгт усан хилийн тэмдэглэл хийж, усан хилийн хамгаалалтыг боловсронгуй болгох; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 35.17 | Хилийн зарим заставыг төвлөрсөн эрчим хүчинд холбох; | төвлөрсөн эрчим хүчинд холбогдох заставын тоо | 3 |
| 35.18 | Хилийн зарим заставыг сэргээгдэх эрчим хүчний 3-5 кВт-ын төхөөрөмжөөр хангах; | сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмжөөр хангах заставын тоо | 45 |

| | | | |
|---|---|---|---|
| 35.19 | Хилийн зарим застав, харуулд шинээр худаг гаргах, усны хатуулаг ихтэй газарт ус цэвэршүүлэх төхөөрөмж тавих; | шинээр гаргасан худаг, уст цэгийн тоо | 9 |
| | | ус цэвэршүүлэх төхөөрөмжийн тоо | 60 |
| 35.20 | Гадаадын иргэдийн бүртгэл, хяналтыг сайжруулах зорилгоор гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн орчныг боловсронгуй болгох; | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 35.21 | Хилийн боомтын талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлогын баримт бичгийг боловсруулах; | - | - |
| 35.22 | Хил хамгаалалтын дэд бүтцийг сайжруулах, анги, салбаруудад ажиллагсдын нийгмийн баталгааг бэхжүүлэх талаар холбогдох арга хэмжээг авах; | - | - |
| 35.23 | 2010 онд хүн амын бүртгэлийн архивыг цахим хэлбэрт оруулж, улмаар 2011 онд иргэдийг "Иргэний ухаалаг үнэмлэх"-тэй болгох бэлтгэл ажлыг хангах; | - | - |
| 35.24 | Хилийн боомтуудын үйл ажиллагааг хэвийн, жигд явуулах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, нүүрсний экспортыг нэмэгдүүлэх зорилгоор Гашуун сухайт, Шивээ хүрэн, Бургастай, Ярантын боомтыг олон улсын стандартын түвшинд хүргэх техник, эдийн засгийн үндэслэлийг эцэслэн боловсруулж, өргөтгөн тохижуулах; | - | - |
| 35.25 | Хилийн заставуудын хашааг шинэчлэх хөтөлбөр хэрэгжүүлэх; | - | - |
| 35.26 | ОХУ-ын Кемерово, Хакаси муж улс болон БНХАУ-ын хил залгаа аймгуудын хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж гадаад худалдааны таатай орчныг бүрдүүлэх; | - | - |
| 35.27 | Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Хөх-Эрэгийн боомтын үйл ажиллагааг сэргээж дундад ази руу гарах гарц нээх. | - | - |

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр | Дугаар 154 | Улаанбаатар хот

**Зарлигт өөрчлөлт оруулах тухай**

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2009 оны 104 дүгээр зарлигийн "7.23. Зндэсний хөгжлийн хүрээлэнгийн захирлыг томилж, чөлөөлнө" гэснийг "Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн бүтцийг баталж, захирлыг томилж, чөлөөлөх бөгөөд Шинжлэх ухааны академитай хамтран тус хүрээлэнгийн дүрмийг батална." гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр | Дугаар 297 | Улаанбаатар хот

**Мал, амьтан нэвтрүүлэх боомтын тухай**

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 5.1.5-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2010 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаагаар улсын хилийн дараахь боомтуудаар мал, амьтан нэвтрүүлэх болон үржлийн мал импортлохыг зөвшөөрсүгэй:

1. Өмнөговь аймгийн Шивээхүрэн;
2. Өмнөговь аймгийн Гашуунсухайт;
3. Булган аймгийн Бага-Илэнх;
4. Сүхбаатар аймгийн Бичигт;
5. Ховд аймгийн Булган;
6. Говь-Алтай аймгийн Бургастай;
7. Баян-Өлгий аймгийн Даян.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** **С.БАЯР**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД** **Т.БАДАМЖУНАЙ**

# МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2009 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр | Дугаар 06 | Улаанбаатар хот

**Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим
12.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн П.Очирбат, Ж.Болдбаатар /илтгэгч/, Д.Наранчимэг, Д.Мөнхгэрэл нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Г.Агар-Эрдэнийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Б.Лхагважав болон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд оролцов.

Хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4 дэх хэсгийн заалтууд Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

**Нэг. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 1 дүгээр хорооны оршин суугч, иргэн Б.Лхагважав Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:**

"Монгол Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4 дэх хэсгийн заалтууд Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Гуравдугаар зүйлийн 1, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, Арван зургадугаар зүйлийн 9, Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Улсын Их Хурлын дарга, ...-ыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн..." гэж заасныг, мөн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудын хэм хэмжээг тус тус зөрчсөн байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4 дэх хэсгийн заалтууд нь энэхүү хуулийнхаа Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг баталгаажуулсан 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтыг шууд утгаар зөрчиж байна.

Монгол Улсын иргэний болон Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхэд халдсан, Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн дээр дурьдсан заалтуудыг хүчингүй болгож өгнө үү" гэжээ.

**Хоёр. Монгол Улсын Их Хурлын даргын 2009 оны 10 дугаар 15-ны өдрийн 154 дүгээр захирамжаар томилогдсон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Г.Занданшатар Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:**

"...Нэг. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4 дэх хэсгийн заалтууд нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх талаар:

...Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлд "Улсын Их Хурлын дарга, дэд даргыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн саналаа илээр гаргаж сонгоно. Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно" гэж заасан. Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлээр Улсын Их Хурлын даргыг сонгох үйл ажиллагааг зохицуулсан. Хуулиар Улсын Их Хурлын даргыг томилдоггүй, төлөөллийн ардчилсан зарчмаар гишүүдийн дундаас нэр дэвшүүлэн, чуулганаар хэлэлцүүлж, санал хураалтаар хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн дэмжлэг авсан бол түүнийг Улсын Их Хурлын даргаар сонгогдсонд тооцож тогтоол гаргадаг журамтай.

Парламентын сонгуульд оролцсон нам, эвсэл тухайн сонгуулийн үр дүнд авсан суудлын тоогоороо олонхи, цөөнх болж, нэр дэвшиж сонгогдсон гишүүд нь өөрийн нам, эвслийн бүлгийг парламентад байгуулдаг. Бүлэг нь парламентын үйл ажиллагаанд ард түмний эрх ашгийн үүднээс намынхаа бодлогыг тусгах гол үүрэгтэй. Үүнийг Улс төрийн намын тухай хуулийн 22 дугаар зүйлд "22.1.2. хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл болон бодлогын талаархи асуудлыг Улсын Их Хурал дахь намын бүлгээрээ, хэрэв намын бүлэггүй бол Улсын Их Хурлын гишүүнээрээ дамжуулан Улсын Их Хуралд оруулах; 22.1.3. Улсын Их Хурал дахь намын бүлгээрээ дамжуулан улс төрийн албан тушаалд нэр дэвшүүлэх санал тавих; 22.1.4. Улсын Их Хурал дахь намын бүлгээрээ дамжуулан Улсын Их Хурлын чуулганы нээлтийн ажиллагаанд улс орны бодлогын асуудлаар байр сууриа илэрхийлэх" гэж заасан.

Бүлэг бол Улсын Их Хурлын зохион байгуулалтын нэг хэлбэр. Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлд "13.1. Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, байнгын болон дэд, түр хороо, намын бүлэг, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ" гэж тодорхойлсон. Улсын Их Хурлын тухай хуулийн 26 дугаар зүйлд зааснаар Улсын Их Хурлын сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал авсан нам, эвсэл бүлэг байгуулах ба бүлэгт зөвхөн тухайн нам, эвслээс нэр нь албан ёсоор дэвшиж сонгогдсон гишүүд орно. Нам, эвсэл бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрсийн жагсаалтыг анхдугаар чуулганаар Улсын Их Хурлын даргыг сонгосноос хойш 24 цагийн дотор Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлнэ. Бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрсийн жагсаалтыг Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаан дээр албан ёсоор мэдээлнэ. Хуулийн дагуу зохион байгуулагдсан бүлэг Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу чуулганаар хэлэлцэж байгаа бүхий л асуудлаар бодлого, байр сууриа тодорхойлж санал, дүгнэлтээ гаргах эрхтэй. Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу Улсын Их Хуралд олонхи болсон нам, эвсэл Улсын Их Хурлын даргын сонгуульд нэр дэвшүүлэх ба олонхи суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл нь бусад нам, эвсэлтэй зөвшилцөн Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлнэ. Нэр дэвшигч санал хураалтаар хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн дэмжлэг авсан бол түүнийг Улсын Их Хурлын даргаар сонгогдсонд тооцож тогтоол батална. Иймд Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4 дэх хэсгийн заалтууд нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчөөгүй гэж үзэж байна.

Хоёр. Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4 дэх хэсгийн заалтууд нь мөн хуулийн 7.1.6 дахь заалттай зөрчилдсөн эсэх талаар:

Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлд "Улсын Их хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална" гэж заасан бөгөөд гишүүний бүрэн эрхийг нь Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлээр хуульчилсан. Бүлэг бол парламентын зохион байгуулалтын нэг хэлбэр бөгөөд гишүүн бүлэгт нэгдэн орох эсэхээ өөрөө шийдвэрлэдэг. Гишүүн Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэгт элсэн орсноороо түүний бүрэн эрх хязгаарлагдаггүй. Улсын Их Хурлын гишүүн нэгдсэн, байнгын болон дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаан дээр хэлэлцэгдэж байгаа аливаа асуудлаар асуулт тавьж хариулт авах,

түүнчлэн үг хэлж байр суурия илэрхийлэх, санал, дүгнэлт гаргах, санал хураалгах, Улсын Их Хурлын дарга, дэд дарга, байнгын, дэд, түр хорооны дарга, Улсын Их Хурлын сонгуульт бусад удирдах албан тушаалд сонгогдох, тэдгээрт өөрийн нэрээ дэвшүүлэх зэрэг бусад бүрэн эрхээ ямар нэгэн гадны нөлөөгүй, хуулийн дагуу хэрэгжүүлдэг. Улсын Их Хурлын тухай хуулийн 9.7-д "Гишүүд байнгын хороо, нам, эвслийн бүлгийн болон нэгдсэн хуралдаан дээр нэр дэвшигчид асуулт тавьж хариулт авах, үг хэлж байр суурия илэрхийлэх эрхтэй" гэж гишүүний эрхийг давхар баталгаажуулсан болно.

Иймд Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4 дэх хэсгийн заалтууд нь мөн хуулийн 7.1.6 дахь заалтын Улсын Их Хурлын гишүүн "Улсын Их Хурлын дарга, дэд дарга, байнгын, дэд, түр хорооны дарга, Улсын Их Хурлын сонгуульт бусад удирдах албан тушаалд сонгогдох, тэдгээрт өөрийн нэрээ дэвшүүлэх;" эрхтэй гэсэн заалттай зөрчилдөөгүй болно" гэжээ.

**Гурав. Монгол Улсын Их Хурлын даргын 2009 оны 10 дугаар 17-ны өдрийн 154 дүгээр захирамжаар томилогдсон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:**

"...Анхдугаар чуулган дээр Улсын Их Хурлын даргыг сонгох үед байнгын хороо, нам, эвслийн бүлгийн санал, дүгнэлт гэж гардаггүй. Учир нь Улсын Их Хурлын даргаа эхэлж сонгосны дараа бүлэг, байнгын хороод зохион байгуулагддаг. Харин Улсын Их Хурлын тухай хуулийн 9.3, 9.4-ийн "нэр дэвшигчийг холбогдох байнгын хороо, түүнчлэн шаардлагатай гэж үзвэл нам, эвслийн бүлгүүд хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргана. Энэ санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж санал хураалт явуулна" гэсэн заалт нь илүүтэй Улсын Их Хурлын даргын бүрэн эрх Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан үндэслэлээр хугацаанаасаа өмнө дуусгавар болсон тохиолдолд шинээр дахин сонгохтой холбогдсон заалт юм.

Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвсэл Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлэх эрхтэй ч Улсын Их Хурлын даргад заавал олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшсэн нь сонгогдох албагүй юм. Юуны өмнө нэр дэвшигч сонгогчдын өмнө хүлээх үүрэг, хариуцлагаа мэдэрч ойлгодог, Улсын Их Хурлыг төлөөлөх чадвартай, нас, мэдлэг, ёс

суртахууны хувьд зохих шаардлагыг хангасан, олонхи болон цөөнхийн ашиг сонирхлын хооронд зуучлагч байх чадвартай, парламентын ёс зүй, улс төрийн соёлыг илэрхийлэгч тийм хүн байх ёстой. Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвсэл иймд үүднээс хандаж нэр дэвшүүлдэг тул гишүүдийн олонхийн дэмжлэгийг авдаг болно.

Өөрөөр хэлбэл Улсын Их Хурлын гишүүдийн нэгдмэл саналыг чухалчилдаг. Улсын Их Хурлын дарга аль нэг нам, эвсэл, олонхийн улс төрийн эрх ашгийг илэрхийлэн хамгаалагч биш гэдгийг үүгээр харуулж байна. 1992-2008 оны хооронд Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлэн сонгохдоо энэ зарчмыг баримталсан гэхэд болно.

...Парламентын нэг онцлог нь гишүүд нь эрх тэгш гэж тооцогдоно. Тэдгээрийн зарим нь дотоод зохион байгуулалтын бүтэцтэй удирдах алба хаших онцгой үүрэг хүлээдэг болно, гэхдээ гишүүний санал ач холбогдлоор адилхан. Өөрөөр хэлбэл, парламент гадагш гаргах шийдвэрээ хамтаар гаргадаг байгууллага. Иймээс гишүүний эрх зүйн байдал нилээд онцлогтой.

"Улсын Их Хурлын дарга, дэд дарга, байнгын, дэд, түр хорооны дарга, Улсын Их Хурлын сонгуульт бусад удирдах албан тушаалд сонгогдох, тэдгээрт өөрийн нэрээ дэвшүүлэх" гэсэн гишүүний бүрэн эрхийг Улсын Их Хурлын тухай хуулийн 7.1.6-д онцгойлон заасан. Энэ эрх хөндөгдөөгүй. Улсын Их Хуралд олонхи цөөнх болсон гишүүний аль нь ч гишүүний үүрэг хариуцлагын хувьд ижил, адилхан бүрэн эрхтэй" гэжээ.

**ҮНДЭСЛЭЛ:**

1. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтаар "Улсын Их Хурлын дарга...-д сонгогдох, тэдгээрт өөрийн нэрээ дэвшүүлэх;" эрхтэй байна. Мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4 дэх хэсгийн заалтаар дээрх эрхийг хязгаарлаагүй байна.

2. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн "Улсын Их Хурал дахь олонхи болсон нам, эвсэл Улсын Их Хурлын даргын сонгуульд нэр дэвшүүлнэ"; мөн зүйлийн 9.2 дахь хэсгийн "Аль ч нам, эвсэл энэ хуулийн 8.1-д заасан суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл нь бусад нам, эвсэлтэй зөвшилцөн Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлнэ"; 9.3 дахь хэсгийн "Энэ хуулийн 9.1, 9.2-т заасны

дагуу нэр дэвшигчийг холбогдох байнгын хороо, түүнчлэн шаардлагатай гэж үзвэл нам, эвслийн бүлгүүд хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргана"; 9.4 дэх хэсгийн "Энэ хуулийн 9.3-т заасны дагуу гаргасан санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж санал хураалтыг илээр явуулна" гэсэн заалт нь Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Улсын Их Хурлын дарга, ...-ыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн... сонгоно"; Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуульд хууль... бүрнээ нийцсэн байвал зохино" гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

**Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4 дэх хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Улсын Их Хурлын дарга, ...-ыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн... сонгоно", Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуульд хууль... бүрнээ нийцсэн байвал зохино" гэснийг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

| | |
|---|---|
| **ДАРГАЛАГЧ** | **Ж.БЯМБАДОРЖ** |
| **ГИШҮҮД** | **П.ОЧИРБАТ**<br>**Ж.БОЛДБААТАР**<br>**Д.НАРАНЧИМЭГ**<br>**Д.МӨНХГЭРЭЛ** |

**Хаяг:**
"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци.
Улаанбаатар-12, Төрийн ордон 128 тоот
И-мэйл: turiin_medeelel@parliament.mn
**Утас:** 262420, 329612
Хэвлэлийн хуудас 4.25
**Индекс: 14003**



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэв.
Утас 329487